

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**



**БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

*Тайлан хянасан:*

*Төсвийн Ерөнхийлөн захирагч*

ЗАСАГ ДАРГА  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

/Н.БАТСҮМБЭРЭЛ/

*Тайлан баталсан:*

*Төсвийн Шууд захирагч*

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

/П.БАЯНБААТАР/

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2022 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
<b>НЭГ. “КОВИД-19” ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>							
Цар тахлын тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, туршигдсан вакцинаар хангах асуудлаар холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллана.							
1.1	Дүүргийн зорилтот хүн ам болон нэн шаардлагатай албан хаагчдыг “Ковид-19” - ийн дархлаажуулалтад бүрэн хамруулах	Улс, дүүргийн төсөв 7.5	Хамрагдсан хүн, амын хувиар	44%	80%	Дүүргийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар Ковидын дархлаажуулалтын 1-р тунд 109,889 хүн буюу 99%, 2-р тунд 98,971 хүн буюу 89%-тай хамрагдсан. Дархлаажуулалтад 3-р тунд 49,384 хүн хамрагдаж 53%-тай, 4-р тунд 7,232 хүн хамрагдаж 9%-тай байна. Дүүргийн 12-17 насны хүүхдийн 1-р тунд 7288 хүүхэд 60%-тай, 2-р тунд 6569 хүүхэд 90%-тай байна. Мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн халдварын эсрэг 1-р тунгийн хамрагдалт 29,5%, 2-р тунгийн хамрагдалт 24,8%-тай байна. 5-11 насны хүүхдийн 1-р тунд 46, 2-тунд 9 хүүхэд хамрагдсан байна.	90
1.2	Цар тахлын халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, нөөцийг хангах, тандалт, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах	Дүүргийн төсөв 200.0	Хэрэгжилтийн хувиар	100%	100%	Ковид-19 халдвартай иргэдийг хэвтүүлэн эмчлэх ор дэлгэсэн байсныг ЭМС-ын тушаалаар 2022 оны 2 дугаар сард татан буулгаж, ЭМС-ын А/547 дугаар тушаалаар зөвхөн шинж тэмдэгтэй иргэдээс шинжилгээ авахаар зохион байгуулалт хийж ажилласан. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг буурсантай холбоотойгоор хариу арга хэмжээний багийг цөөлж, дуудлагын төвийг буулган ЭМТ-д	

					<p>шилжүүлэн эмнэлэгт хэвтүүлэхтэй холбоотой тусламж үйлчилгээг үзүүлж байна. Шинжилгээний цэг өдөр бүр 09-12 цагийн хооронд, дархлаажуулалтын цэгүүд ажлын өдрүүд болон амралтын өдрүүдэд төлөвлөлтийн дагуу ажиллаж байна. ЭМС-ын 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн амбулатори ажиллуулах тухай” 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд цар тахлын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах зорилгоор Хайлааст хүүхдийн салбар “коронавирусын халдвар”-тай иргэдэд эмнэлгийн үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүллээ. 2022 онд дотрын эмч, хүүхдийн эмч, дүрс оношилгооны эмч, бүртгэлийн ажилтан, үйлчлэгч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр амбулаторийн “УЛААН БҮС”-д ажиллаж 1031 насанд хүрэгчид, 265 хүүхдэд, 1296 хүнд тусламж үйлчилгээг үзүүлсэн. 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн Омикрон хувилбарын дэгдэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор ковидын амбулаторийг дахин ажиллуулсан бөгөөд нийт 112 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Халдварын дэгдэлт буурахтай холбоотойгоор Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвд ковидын амбулаторийг шилжүүлэн ажиллуулж байна. Цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан НЭМГ-аас ковидын амбулаторийн үйл ажиллагааг 2022 оны 08 сарын 01-ний өдрөөс татан буулгасан.</p>	
--	--	--	--	--	--	--

1.3	Халдварт цар тахлын эрсдэл нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг хангах ажлуудад зарцуулах төсвийн санхүүжилтэд хяналт тавина.	Дүүргийн төсөв 705.0	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	2021 онд Засаг даргын нөөц хөрөнгө 563.5 сая төгрөг буюу 70.4 хувь, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 256.3 сая төгрөг буюу 100	Батлагдсан төсвийн санхүүжилт зарцуулалтад хяналт тавьж ажиллах	Халдварт цар тахлын эрсдэл нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээтэй холбоотой дүүргийн Засаг даргын 2022 оны захирамжийн дагуу Засаг даргын нөөц сангаас 110.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Мөн 2022 оны жилийн эцсийн байдлаар ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэхэд хөрөнгө зарцуулаагүй байна.	100
-----	---	-------------------------	----------------------------------	---	---	--	-----

### ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

#### 2.1 ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг дэмжин ажиллана.

2.1.1	Эрүүл мэндийн мобайл технологийн иж бүрдэлтэй ӨЭМТ-үүдийн тоог нэмэгдүүлэх.	70.0 Дүүргийн төсөв	ӨЭМТ-ийн тоо	6	7	Дүүргийн ӨЭМТ-үүдийг эрүүл мэндийн мобайл технологийн иж бүрдлээр бүрэн хангах, эрүүл мэндийн мобайл технологийн иж бүрдлийн халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлэх түргэвчилсэн оношлуур /В, С вирус, ДОХ/БЗДХ, тэмбүү, цусан дахь глюкоз, холестерин, хеликобактер, хавдрын маркерууд/-ын нэр төрлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн 11, 12, 13, 17, 18, 19 дүгээр хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүд мобайл технологийн тоног төхөөрөмжийг ашиглаж байна. Мобайл технологийн тоног төхөөрөмж ашиглан иргэдийн цусны даралтыг хэмжиж, биеийн жингийн индексийг тодорхойлон зүрхний цахилгаан бичлэг хийж, чихрийн шижингийн эрсдэлийн үнэлгээг асуумжаар авч шаардлагатай иргэдийн цусан дахь сахрыг тодорхойлж зөвлөгөө өгөх ажлыг 3 удаа зохион байгуулж, 672 хүнийг хамруулсан.	70
-------	---	------------------------	--------------	---	---	--	----

2.1.2	“Эрүүл иргэн, өрх, байгууллага хамт олон”-ыг шалгаруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах.	6.0 Эрүүл мэндийн төв	Эрүүл иргэн, өрх, байгууллагын тоо	0	2	Дүүргийн хороодын Өрхийн Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран “Эрүүл иргэн, өрх, байгууллага, хамт олон”-ыг шалгаруулах ажлыг 2022 оны 3 дугаар улиралд зохион байгуулж, удирдамжийг хороодын Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан иргэд, ААНБ-д хүргүүлж, “Эрүүл мэндийг дээдлэгч иргэн”-4, “Эрүүл мэндийг дээдлэгч өрх”-3, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-3-ыг тус бүр шалгаруулан холбогдох материалыг дүүргийн ЗДТГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 3/2371 дугаарын албан бичгээр НЭМГ-т хүргүүлсэн. “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллагаар дүүргийн 31, 37 43 дугаар цэцэрлэгүүд, “Эрүүл мэндийг дээдлэгч иргэн”-ээр дүүргийн 3 иргэн тус тус шалгарсан.	100
2.1.3	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах сургалт сурталчилгааг өргөжүүлэх.	35.0	Хийсэн сургалт, үйл ажиллагааны тоо	2	4	Тайлант хугацаанд эрүүл мэндийн боловсрол, мэдлэг олгох чиглэлээр аян 2, өдөрлөг 10, сургалт сурталчилгаа 70, нийт 82 арга хэмжээнд давхардсан тоогоор 45,600 гаруй иргэд хамрагдсан. Нийслэлийн Эрүүл мэндийн газар, АШУҮИС, АНУ-ын Лома Линдагийн Их сургууль, дүүргийн ЭМТ хамтран хэрэгжүүлж буй “Тамхинаас гарах интервенцэд 116 иргэн хамрагдаж табекс эм эсвэл наалтаас сонгон хэрэглэж холбогдох сургалтуудад хамрагдан тамхинаас татгалзах алхмыг хэрэгжүүлсэн ба 98 иргэн тамхинаас гарсан. “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд дүүргийн иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнд уриалан дүүргийн хэмжээнд 8 заал, 14 танхимд өглөө бүр 06:30-07:30 цагийн хооронд иргэдийг үнэ төлбөргүй, дасгал хөдөлгөөн хийх нөхцөлөөр хангаж,	90

						14-73 насны нийт 39000 иргэнийг хамруулсан.	
2.1.4	“Орбис” ОУ-ын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх хүн амын дундах чихрийн шижин өвчний хяналтыг сайжруулах төслийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Сургалт, үйл ажиллагааны тоо	1	3	Дүүргийн хүн амын дундах чихрийн шижин өвчний хяналтыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх чиглэлээр дүүргийн Засаг дарга, “Орбис” ОУ-ын байгууллага хамтран ажиллах санамж бичиг байгуулах бэлтгэл ажлыг хангасан ба “Орбис” ОУ-ын байгууллагатай хамтран 2022-2024 онд хэрэгжүүлэх “Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх” 5 бүлэг, 23 үйл ажиллагаа бүхий ажлын төлөвлөгөөг батлуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд “Чихрийн шижин болон чихрийн шижингийн шалтгаант ретинопатийн тусламж үйлчилгээний загвар бий болгох” төслийн нэгжийн мэргэжилтнүүд болон хамтран төсөл хэрэгжүүлэгч нарт нийгмийн маркетингийн талаар танилцуулж, цаашдын төлөвлөгөөний талаар 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр цахимаар уулзаж санал солилцсон. Төлөвлөгөөний дагуу чихрийн шинжин өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор “Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлье” уриан дор “Чихрийн шижин түүний хүндрэлээс сэргийлэх” сэдэвт сургалтыг 16 сувилагч, 16 эмчийг хамруулан 1 удаа зохион байгуулж, дүүргийн 1-24 дүгээр хороодын залуучуудыг хамруулсан явган алхалтыг 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж, 150 залуучуудыг хамруулсан.	100
2.1.5	Дүүргийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл”-ийн	Дүүргийн төсөв 5.0	Төлөвлөгөөний	0%	30%	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл”-ийн 2022 онд хэрэгжүүлэх 5 бүлэг 25 үйл ажиллагаа	90

	2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.		хэрэгжилтийн хувь			бүхий төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн Ерөнхий газарт болон НЗДТГ-т тус тус хүргүүлж ажилласан. Нийслэлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлд үйл ажиллагааг танилцуулах ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргад 2022 оны байдлаар зорилтот бүлгийн нийт 167 иргэнээс тусламж, дэмжлэг хүссэн өргөдөл, хүсэлт ирүүлснээс “Нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу 24 хөгжлийн бэрхшээлтэй иргэний өргөдөл хүсэлтийг 25,000,000 (хорин тав сая) төгрөгөөр шийдвэрлэсэн. Засаг даргын 2022 оны А/349 дүгээр захирамжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах олон улсын өдрийг тохиолдуулан дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонсох, тэдний санал хүсэлтийг төрийн байгууллагын бодлого үйл ажиллагаанд тусгах чиглэлээр “Өөрчлөлтийг хамтдаа” сэдэвт уулзалт, өдөрлөгийг 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.	
2.1.6	“Хотын хөгжлийн индекс”-ийн 2021 оны маягтуудыг <a href="http://happycity.mn/">http://happycity.mn/</a> программд шивэлт хийж, холбогдох дээд байгууллагад хүргэн ажиллах.	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	30%	70%	Хотын хөгжлийн индексийн хороодоос гаргах 17 төрлийн маягтыг 15 боть болгон архивлаж, архивд хүлээлгэн өгсөн. Дүүргийн 2021 оны “Хотын хөгжлийн индекс”-ийг тооцож, индексийг өсгөх арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын орлогчоор батлуулан, 2021 оны хотын хөгжлийн индексийн тоон үзүүлэлтийг 15 маягтын үзүүлэлтийн дагуу тооцож, <a href="http://happycity.mn/">http://happycity.mn/</a> программд шивэлт	100

						хийж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст илгээж баталгаажуулсан.	
<b>2.2 БИЕИЙН ТАМИР, СПОРТ</b>							
Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилго бүхий “Чингэлтэй лиг” олон төрөлт уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулна.							
2.2.1	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг уралдаан тэмцээнд оролцуулах.	Орон нутгийн төсөв 132.0	Авсан медалийн тоо	184	250	Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2022 оны А/39 дүгээр захирамжаар “Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөл” байгуулсан ба Өсвөрийн шигшээ багийн төрлийг сонгох, багш дасгалжуулагч нарын сонгон шалгаруулалтыг явуулах асуудлаар 2 удаа хуралдсан. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийг спортын 15 төрлөөр хичээллүүлэх шийдвэр гарч, багш дасгалжуулагчдыг сонгон шалгаруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга болон Биеийн тамир, спортын хорооны даргатай “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан. Дүүргийн Засаг даргын зүгээс багш дасгалжуулагч нарт үнэмлэх олгох ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Өсвөрийн шигшээ багуудын бэлтгэл сургуулилыг хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж, тайлант хугацаанд нийт 4470 цагийн бэлтгэлд давхардсан тоогоор 2500 тамирчин хамрагдсан. Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн тамирчид Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд 2, Олон улсын тэмцээнд 6, Улсын аварга шалгаруулах тэмцээнд 10, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд 11, Нэрэмжит тэмцээнд 24 нийт 53 тэмцээнд амжилттай оролцож 261 медаль, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 медаль, Олон улсын тэмцээнээс 25 медаль, Улсын аварга	100



						шалгаруулах тэмцээнээс 98 медаль, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнээс 44 медаль, Нэрэмжит тэмцээнээс 92 медаль тус тус хүртэж, нийт 40 удаагийн уралдаан тэмцээнд оролцож 250 медаль багц медаль хүртсэн амжилт үзүүлсэн.	
2.2.2	Ахмад, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд дүүргийн аварга шалгаруулах спортын тэмцээн уралдааныг зохион байгуулах.	Улсын төсөв 11.160	Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	-	12/1030	Дүүргийн “Ахмадын аварга шалгаруулах” спортын 4 төрөлт тэмцээнийг зохион байгуулах удирдамж хөтөлбөрийг батлуулж, софт волейбол, волейбол, хийн дасгалын тэмцээнүүдийг зохион байгуулж, давхардсан тоогоор 48 хорооны 426 ахмад тамирчин хамрагдсан. Дүүргийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аварга шалгаруулах” спортын 3 төрөлт тэмцээнийг 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд зохион байгуулж, нийт 86 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан.	100
2.2.3	Дүүргийн залуучууд аварга шалгаруулах 3 төрөлт Лигийн тэмцээнийг зохион байгуулж, иргэдийг идэвхтэй хамруулах.	Орон нутгийн төсөв 12.040	Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	-	3/800	Дүүргийн залуучуудын аварга шалгаруулах Лигийн тэмцээнийг хөл бөмбөг, сагсан бөмбөг, волейбол гэсэн 3 төрлөөр 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, нийт 49 байгууллагын 800 гаруй тамирчид хамрагдан хурд хүчээ сорин өрсөлдсөн.	90
2.2.4	Засгийн газрын тогтоолын хүрээнд зохион байгуулагддаг уралдаан, тэмцээнд иргэдийг хамруулах, оролцоог хангах.	Орон нутгийн төсөв 24.0	Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан тамирчдын тоо	26/250 0	26/3850	“Монголын “Үндэсний спорт”-ын VII их наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээний “Мөсний шагайн харваа”, “Мөсөн сурын харваа” Ширээний шагай, шагайн харваа, сурын харваа төрлүүдээр зохион байгуулж, давхардсан тоогоор 52 байгууллагын 659 тамирчин хамрагдсан. Монголын Бүх Ард Түмний спортын их	100

						<p>наадмын Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 20 төрлөөр сонгон шалгаруулж, 315 байгууллагын 4215 тамирчин, Монголын Бүх ард түмний спортын XV наадмын шигшээ тэмцээнүүд 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 18-ны өдрүүдийг хүртэлх хугацаанд амжилттай зохион байгуулж, тэмцээнд аймаг дүүргүүдээс шалгарсан 4570 орчим тамирчин 561 багц медалийн төлөө өрсөлдсөн ба дүүргийн баг тамирчид спортын 22 төрөлд 221 тамирчин, хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж (25 алт, 13 мөнгө, 19 хүрэл) хүртэж, багийн нийлбэр дүнгээр 2 дугаар байр шалгарсан амжилт үзүүлсэн. “Хүй мандал дэвжээ”-нд зохион байгуулагдсан спортын 13 төрөлт тэмцээнд 9 дүүрэг 21 аймгийн 1700 гаруй баг, тамирчид оролцсон ба дүүргийн баг, тамирчид спортын 10 төрөлд 96 тамирчин хурд хүч, авхаалж самбаа, цэц мэргэнээ сорин өрсөлдөж 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж, багийн нийлбэр дүнгээр 2 дугаар байранд шалгарч цом медаль, өргөмжлөлөөр шагнагдсан. Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 16 төрлөөр амжилттай зохион байгуулж 213 байгууллагын 4676 тамирчид хамрагдсан.</p>	
2.2.5	“Нийслэлийн иргэдийн спортын их наадам”-д дүүргийн иргэдийг оролцуулах.	Улсын төсөв 20.0	Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан тамирчдын тоо	8/4500	8/500	<p>Нийслэлийн Иргэдийн спортын X их наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж нийт 8 төрөлт тэмцээн уралдааныг дүүргийн Биеийн тамир, спорт хороо, Хайрхан хөгжлийн төв, Чингэлтэй хайрхны</p>	100

						Зүрх уул, Ерөнхий боловсролын 149 дүгээр сургуулийн спорт зааланд тус тус амжилттай зохион байгуулж, тэмцээнд нийт 116 багийн 2368 тамирчид амжилттай оролцож, Багийн нийлбэр дүнгээр 1-р байранд Э.Ачбаяр Засаг даргатай 6 дугаар хороо, 2-р байранд Н.Сэргэлэн Засаг даргатай 16 дугаар хороо, 3-р байранд Г.Энхтөгс Засаг даргатай 13 дугаар хороо тус тус шалгарсан.	
2.2.6	“Улаанбаатар марафон” олон улсын гүйлтийн тэмцээнд ажилтан, албан хаагч, иргэдийг оролцуулах.	Улсын төсөв 2.0	Хамрагдсан иргэдийн тоо	-	3500	Дүүргийн иргэдийг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” олон улсын гүйлтийн тэмцээн 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан ба дүүргийн төрийн болон төрийн бус аж ахуй нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэд, сурагчдаас бүрдсэн нийт 2200 иргэд хамрагдсан.	90
2.2.7	“Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг”-аар ББХЧТТ Сорил авах, ажилтан, албан хаагчдыг хамруулах.	Улсын төсөв 8.0 Орон нутгийн төсөв 1.0	Хамрагдсан иргэдийн тоо	-	13.800	Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Бие бялдрын түвшин тогтоох сорилыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс авч эхэлсэн ба 86 төрийн болон төрийн бус аж ахуй нэгж байгууллагуудын нийт 13,278 иргэд, төрийн албан хаагчдыг хамруулсан. Үүнээс 58,2% нь А, В, С үнэлгээ авсан байна.	100
<b>2.3 БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН</b>							
Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын хичээлийн чанарыг ахиулах, сэтгэлгээний өндөр хурдтай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “Оюунлаг Чингэлтэйчүүд” төслийг хэрэгжүүлнэ.							
2.3.1	Зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах ажлыг зохион байгуулах.	-		3	5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах орчин, амьдралын нөхцөл, боловсролд хамрагдах онцлог байдлыг харгалзан боловсролд тэгш хамруулах асуудлыг дэмжиж ажиллах чиг үүрэг бүхий “Боловсролд хамрагдалтыг дэмжих	90

			Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо			зөвлөл"-ийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/54 дүгээр захирамжаар байгуулагдсан. Зөвлөлийн хуралдааныг 3 удаа зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтын чиглэлээр дүүргийн боловсролын байгууллагуудад хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, сайн туршлагуудыг сурталчлан түгээх, эцэг эхчүүдийн болон боловсролын байгууллагуудын оролцоог сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээг хүргэх ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр холбогдох үүрэг чиглэл өгч, зөвлөн тусалж ажиллалаа. Ерөнхий боловсролын 149 дүгээр дунд сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах бүрэн боломж бүрдсэн. 2022-2023 оны хичээлийн жилд СӨББ-ын 37 цэцэрлэгт 60 суралцагч, Ерөнхий боловсролын 20 сургуульд 76 сурагч шинээр элсэн суралцаж байгаа ба анги удирдсан багш ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулан хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/54 дүгээр захирамжаар "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл" байгуулан ажиллаж 11 хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлан хамруулж, ХБХ –ийн эрхийн зөрчилтэй 3 кейсийг 100% шийдвэрлэн ажилласан.	
2.3.2	Хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулах.	-	Хамрагдсан сурагчдын тоо	1000	2000	Дүүргийн хэмжээнд зохион байгуулдаг "Хэл хуур"-ын сургалтад Ерөнхий боловсролын сургуулиудын дунд ангийн 30 сурагч хамрагдсан. "Огторгуйн биелгээ" сургалтын төвийн биелгээ, хэл хуурын багш Б.Батням удирдлага дор хичээллэж байна. Тус үйл	100

					<p>ажиллагааны хүрээнд ОХУ-ын Саха Якут дахь Олон улсын хэл хуурын төв, Дэлхийн ард түмний хэл хуурын музейн багш нар цахимаар болон танхимаар уулзалт зохион байгуулан “Монголын хэл хуурын музей”-г 61 дүгээр сургууль дээр нээсэн. “Номтой нөхөрлөө” аян зохион байгуулж, нийт сургууль, цэцэрлэгүүд номын хавчуурга, номын баринтаг, Мини номын сан, номын богц хийн туршлага хуваалцсан. Чингэлтэй дүүргийн Соёлын төвөөс зохион байгуулсан “Завсарлагааны бүжиг” аянд төрийн өмчийн 19 сургууль нэгдэн 61, 50 дугаар сургуулиуд тэргүүн байр эзэлсэн. Цэрэг спортын Дөл үзүүлэх тоглолт 3 үе шаттай зохион байгуулагдаж, 24 дүгээр сургуулийн Хар сүлд баг дүүрэгт тэргүүн байр, улсад 2 дугаар байр эзэлсэн. Зэвсэгт хүчний 101 жилийн ойг угтан ахлах ангийн сурагчдын дунд зохион бичлэг, дунд ангийн сурагчдын дунд зургийн уралдаан зарлаж, 148 сурагч зохион бичлэгээр, 170 сурагч зургийн бүтээлээр оролцсон. НЗДТГ, НБГ, НГБХЗХГ “Зөв эр хүн” НҮТББ-тай хамтран ЕБС-ийн ахлах ангийн хөвгүүдийн дунд зохион байгуулсан “Boys meeting” үйл ажиллагаанд дүүргийн 19 сургуулийн 95 хөвгүүн, 15 нийгмийн ажилтан оролцон улмаар дүүргийн “Хөвгүүдийн анхдугаар чуулга уулзалт”-ыг зохион байгуулж, 26 сургуулийн хөвгүүдийн зөвлөлийн чиглүүлэгчид оролцсон. Дүүргийн Засаг даргын санаачилгаар төрийн өмчийн цэцэрлэгүүдэд Монтессори, Шимт, Аймбрийк ОУ-ын хөтөлбөрүүдийг нийт 11 цэцэрлэгүүдэд хэрэгжүүлж байна.</p>	
<p>Шинээр сургууль, цэцэрлэг барих, өргөтгөх замаар цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургуулийн анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэх ажлыг хэрэгжүүлнэ.</p>						

2.3.3	Сургууль, цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах.	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	3	5	<p>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/53 дугаарын захирамжаар Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Боловсролын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс хамтран нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй 5 баг хяналт шалгалт хийн 2022 оны 03 дугаар сард 1-19 дүгээр хорооны нийт 43 нийтийн эзэмшлийн тоглоомын талбай, 27 сургууль, 57 цэцэрлэг, нийт 127 байршилд хяналт, үнэлгээ, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, зөрчлийг арилгаж ажилласан. Хүүхдийн төлөө зөвлөлийн нэгдүгээр хуралдааны шийдвэрээр дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн талбай болон сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр баталсан хуваарийн дагуу Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын хамтарсан хяналт, шалгалтыг 1-19 дүгээр хороодын нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн талбай, Ерөнхий боловсролын нийт 20 сургууль, 39 цэцэрлэгийн гадна болон дотор орчинд хяналт тавьж, нийт 35 зөрчлийг илрүүлж, холбогдох албан тушаалтан, байгууллагад уламжлан зөрчлийг үе шаттай арилгуулан ажилласан. Шар дарцгийг хэрхэн хэрэглэх, Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдалд хэрхэн зөв дадал хэвшилтэй оролцох сургалт сурталчилгаа, цахим контент мэдээ мэдээллийг бэлтгэж ажилласан. Замын хөдөлгөөнд болон ахуйн нөхцөлд осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх</p>	90
-------	--	---	---------------------------------------	---	---	---	----

						агуулгатай зөвлөмж, пастор, бичлэгүүдийг 7 хоног бүр Боловсролын хэлтсийн цахим хуудсанд байршуулж, 7 хоногт дунджаар 40000 хүний хандалт авч байна. Дүүргийн ЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд “Ногоон гэрэл-Цагаан шугам” уралдааныг зохион байгуулж 17 сургуулийн нийт 204 сурагч оролцсон.	
Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Чадварлаг багш-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг сайжруулж, индексийн урамшууллыг олгоно.							
2.3.4	БСШУЯ-аас 2022 оныг “Ёс зүйн” жил болгон зарласантай холбогдуулан дүүргийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг мөрдөн, харилцаа хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах.	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	1	3	Дүүргийн Ахмадын хороотой хамтран Төрийн өмчийн ерөнхий боловсролын 18 сургуулийн 3000 гаруй багшид “Ёс зүй”, “Инноваци” сэдвээр сургалт зохион байгуулсан. “Эртэч Монгол” аяны хүрээнд СӨББ-ын 9, 19, 74, 103, 277, 275, 291, 292, 298 дугаар цэцэрлэгүүдийн 260 багш ажилтан албан хаагчдад 07.00 - 08.00 цагийн хооронд СӨБ хариуцсан мэргэжилтэн “Багшийн ёс зүй харилцаа хандлага” сэдвээр сургалт зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 17, 72, 117 дугаар сургууль, 56, 83, 102, 293 дугаар цэцэрлэгүүд “Багшийн ёс зүй харилцаа хандлага”, Ёс зүйтэй багш ажилтан гэж хэнийг хэлэх вэ” Ёс зүйтэй байснаар хандлага хэрхэн өөрчлөгддөг вэ” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 280 багш ажилтан хамрагдсан. Дүүргийн шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний хурлыг “Боловсролын салбар дахь ёс зүйн асуудал, шийдэл” сэдвийн хүрээнд зохион байгуулж нийт 51 багш, удирдах ажилтан оролцож, 23, 24 дүгээр сургууль, 275, 39, 74 дүгээр цэцэрлэгийн багш нар эхний 3 байрыг эзэлсэн.	90

**2.4 ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ДААТГАЛ**

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн дотоод гадаад төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллана.

2.4.1	“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөрийн харилцааны LMIS программд иргэдийн мэдээллийг бүртгэж, дээд шатны байгууллагад илгээх.	-	Үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо	1208	1300	“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд “LMIS” программын шинэчлэлд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг сайжруулах талаарх саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн ба тус программ E-Job программ болон шинэчлэгдсэн. Тус платформын сургалтад холбогдох байгууллагын мэргэжилтнүүд 2 удаа хамрагдаж төрийн мэдээллийн бусад системтэй холбогдсон, 11 модуль дэд системээс бүрдсэн платформ дээр хэрхэн ажиллах, ажил хайгч, ажил олгогчдыг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан ажилд зуучлах талаар суралцсан.Тайлант хугацаанд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээний хүрээнд 2000 иргэнд хөдөлмөр эрхлэлт, мэргэжил сонголтын талаар сургалт, зөвлөгөө мэдээллийг өгч, сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалга 1000, ажил идэвхтэй хайж байгаа 995 иргэнийг бүртгэн, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 756 иргэнийг тохирох ажлын байранд зуучилсан. Шинээр бий болсон 500 ажлын байр, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан 1100, нийт 6351 иргэний мэдээллийг LMIS программд шивж оруулсан.	100
2.4.2		-	Цахимжсан үйлчилгээний тоо	22	25	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор зарим төрлийн үйлчилгээг иргэний нэрийн дансанд шилжүүлэх ажлыг арилжааны банкнуудтай хамтран үе	100



	<p>“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд халамжийн үйлчилгээг цахимжуулж E.Halamj программаар үйлчилгээг хүргэх</p>					<p>шаттайгаар зохион байгуулж, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээнд хамрагдах эрх үүссэн 19.547 иргэдийн өргөдөл, хүсэлтийг www.ehalamj.mn цахим системээр хүлээн авч, цаг хугацаанд нь хууль, журмын дагуу шийдвэрлэн ажилласан. 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар www.ehalamj.mn цахим системд нэг цэс 15 үйлчилгээг нэвтрүүлсэн байна.</p>	
2.4.3	<p>“Хөдөлмөрийн аюулгүй байдлын салбар зөвлөл”-н үйл ажиллагааг идэвхжүүлэн ААНБ-д ХАБ-н талаарх мэдээлэл, зөвлөгөөг хүргэн ажиллах.</p>	<p>Засаг даргын нөөц хөрөнгө 5.0</p>	<p>Танилцуулга хийгдсэн ААНБ-н тоо</p>	<p>ААНБ-5</p>	<p>АННБ-10</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, ХБНГУ-ын физик техникийн хүрээлэнтэй хамтран “Уул уурхайн салбарт тоос тоосжилтоос шалтгаалсан өвчлөл, хөдөлмөрийн аюулгүй байдал” бага хуралд 3 аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийг оролцуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны нээлтийн арга хэмжээг “Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг хандлагыг хамтдаа төлөвшүүлье” урианы дор 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, арга хэмжээнд дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дүүргийн Улаан загалмайн хороо, Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль хамтран оролцож, давхардсан тоогоор 600 гаруй ажилтан, албан хаагч, иргэд, оюутан залуусыг оролцуулсан. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн талаар 356 ажилтан, 171 ажил олгогч байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг өгч 12 удаа сургалт зохион байгуулж 388 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч “Мэдлэгт суурилсан ХАБЭА-н эерэг соёлыг түгээе” аяныг цахим пэйж хуудсаар дамжуулан мэдлэг олгох зурагт мэдээлэл,</p>	90

					<p>сэрэмжлүүлэг зэрэг 19 удаагийн мэдээллийг 160 гаруй группт түгээгдэж нийт 12.000 гаруй хүнд хүрсэн байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын захиалгаар хийгдэж буй "Хөдөлмөрийн тухай хуулийн 144 хэрэгжилтэд хөндлөнгийн мониторинг хийх судалгааны багт ажиллаж, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 30 аж ахуйн нэгж байгууллагаас судалгааг авсан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан "Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн маргаан зохицуулалтын талаар аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, албаны дарга, хөдөлмөрийн харилцаа хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалт"-д 1 албан хаагчийг хамруулсан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв хамтран зохион байгуулсан "Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2021" шалгаруулах ёслолын арга хэмжээнд 1 албан хаагчийг оролцуулж, эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллагын шилдгээр шалгарсан Улаанбаатар Төмөр замын татах хэсгийн өдөр тутмын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа, сайн туршлагатай танилцсан. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн салбарын аж, ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/219 дугаарын захирамжаар</p>	
--	--	--	--	--	--	--

						байгуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн эрүүл мэндийн салбарын улсын үзлэгийг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулсан.	
Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.							
2.4.4	Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, заавал даатгуулагч болон ажил олгогчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, ажлыг сурталчлан зохион байгуулах, тоог нэмэгдүүлэх.	-	Зохион байгуулагдсан ажил, иргэний тоо	4550	5000	Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах чиглэлээр нийт 59 арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: 11 удаагийн сургалт, үйл ажиллагаагаар нийт иргэнд мэдээлэл хүргэсэн, тоон гарын үсгээр нийт <b>1260</b> байгууллагын тайланг хүлээн авч ажиллаж байна. Нийт 2000 гаруй байгууллагын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнууд хамрагдсан ба тайлан илгээхэд анхаарах асуудал, цахим тэтгэмжийн үйлчилгээ, тэтгэмжийн хүсэлтийн цахимаар илгээх заавар, тоон гарын үсгийн танилцуулга зэрэг 4 төрлийн <b>5484</b> ш гарын авлага брошюр тарааж ажилласан. Дүүргийн хэмжээнд 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр шинээр нийт <b>552</b> аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр бүртгэж, <b>3461</b> албан журмын даатгуулагчийг хамруулж, нийгмийн даатгалын шимтгэл <b>3,846,2</b> сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Мөн тайлант хугацаанд нийт <b>14172</b> сайн дурын даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдсан байна. Үүнээс шинээр <b>2800</b> даатгуулагч, <b>1410</b> эхчүүдтэй сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажилласнаар нийгмийн даатгалын санд <b>5,3187,6</b> сая төгрөг төвлөрүүлсэн. НДЕГ-аас 2022 оныг “Эрхзүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил” болгон	100

						зарласантай холбогдуулан тус хэлтэс нь тоон гарын үсэг ашиглан тайлан гаргадаг ажил олгогч байгууллагуудын тоог нэмэгдүүлэхээр байцаагч тус бүр өөрийн хариуцсан ажил олгогч байгууллагуудад тайлан өгөх талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар <b>НИЙТ 1260</b> ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр хүлээн авч ажиллаж байна.	
2.4.5	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний аппликейшныг хэрэглээг нэмэгдүүлэх, шимтгэл төлөлтийн талаарх QR код бүхий архивын лавлагааг иргэд даатгуулагчдад олгож хэвших.	-	Үйлчилгээ авсан иргэний тоо	1552	1700	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний аппликейшныг даатгуулагчийн гар утсанд суулгах, сайн дурын даатгалын гэрээг аппликейшн ашиглан цахимаар байгуулах, сунгах талаар зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж, аппликейшны хэрэглээг нэмэгдүүлэн ажиллаж байна. 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн CALL CENTER үйлчилгээг шинээр нэвтрүүлж, шууд холбогдох утсыг ажиллуулж, нийт <b>11950</b> гаруй иргэд, даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл өгч байна. Мөн тус ажлын хүрээнд нийт <b>9</b> арга хэмжээ , <b>6</b> сургалт, <b>3</b> төрлийн зурагт хуудас танилцуулга материал бэлтгэн, <b>598</b> гаруй даатгуулагчийн гар утсанд аппликейшн суулган баталгаажуулж, нийт <b>14172</b> сайн дурын даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдсан байна. Үүнээс шинээр <b>2800</b> даатгуулагч, <b>1410</b> эхчүүдтэй сайн дурын даатгалын гэрээ байгуулсан. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх архивын лавлагааг <b>5364</b> иргэд даатгуулагчдад цахимаар /QR кодтой/ болгон ажиллаж байна. “Дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем”-ийг нэвтрүүлэн, киоск машиныг ашиглан нийт <b>12982</b> иргэн дугаар	100

						<p>авч үйлчлүүлснээс <b>13588</b> үйлчилгээг үзүүлж ажилгүйдлийн тэтгэмжийн зөвлөгөө <b>1035</b> даатгуулагч иргэн, нийгмийн даатгалын тайлан хүлээн авах баталгаажуулах <b>5072</b>, тэтгэврийн мэдээлэл зөвлөгөө авсан <b>2485</b>, өргөдөл <b>1074</b>, бусад зөвлөгөө мэдээлэл <b>3922</b> үйлчилгээг үзүүлж, үйлчилгээ үзүүлсэн төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх боломжтой бөгөөд үнэлгээ өгсөн дундаж оноо нь <b>4,8%</b> байна. Ингэснээр иргэдийн сэтгэл ханамжийн түвшин тодорхойлон тус Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг дүгнэх, байцаагч ажилтнуудын ажлын ачааллыг хэмжих, ажлын үр дүнг бодитой үнэлэх зэрэг ач холбогдолтой юм. Иргэд даатгуулагчдыг сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний байцаагч нарын товч мэдээлэл бүхий QR кодыг хийж, байцаагч тус бүрийн өмнө байршуулан иргэд даатгуулагчдад сурталчлан, мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн уг төхөөрөмжийг ашиглан нийгмийн даатгалын шимтгэл төлөх дансны дугаарыг харах, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хэвлэж авах бүрэн боломжтой болсон.</p>	
--	--	--	--	--	--	--	--

**2.5 ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛ**

Гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Гэр бүл-2024" арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.

2.5.1	Хүүхдийн өөрөө удирдах байгууллага, сургуулийн өөрөө удирдах байгууллагатай хамтран хүүхдийг хүчирхийлэл, гэмт хэрэг	Орон нутгийн төсөв 4.0	Хамрагдсан хүүхдийн тоо	2 үйл ажилла гаанд 240 хүүхэд	300	Жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдөр буюу "Хүүхдийг зодож, шийтгэхийн эсрэг Дэлхийн өдөр"-ийг угтан нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЗДТГазар, ГХУСАЗСЗ, ДЗМОУБ-ын Хайлааст ОНХ-тэй хамтран	90
-------	--	------------------------	-------------------------	-------------------------------	-----	--	----

	<p>зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх.</p>				<p>“ШИЙТГЭЛ БОЛ ШИЙДЭЛ БИШ” аяныг ДЗМОУБ-тай 1 сарын хугацаанд зохион байгуулж, аяны хүрээнд хүүхдийн дуу хоолойг сонсох, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар гэр бүл, олон нийтийн зөв хандлагыг бий болгох чиглэлээр нэг сарын хугацаанд нийт 5 удаагийн танхимын сургалтад 1800 гаруй сурагч, эцэг, эх, асран хамгаалагчийг, 4 удаагийн хэлэлцүүлэг, чуулганд 27 мянга гаруй сурагчдын хамруулж, хүүхэд хамгааллын чиглэлээр 4 удаагийн шторк, 8 удаагийн пастор мэдээллийг цахимаар түгээж, 30 мянга гаруй иргэдэд нөлөөллийн ажлыг хүргэсэн байна. Хүүхдийн эрхийг хангах, боловсролын орчныг сайжруулах, хүүхдийг бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллахад хүүхдийн дуу хоолойг сонсох, хүүхдүүдийн санал хүсэлтийг хүлээн авах зорилготой “Хүүхдээ сонсьё” чуулганд оролцсон Ерөнхий боловсролын сургуулийн 151 сурагчийг нийслэлийн Чингэлтэй дүүргийн “Засаг даргын элч-Сурагч”-аар батламжилж, үнэмлэх гардуулсан. Мөн “Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй, “Өглөөний цайг өөртөө” “Сургуулийн тогоочдоо тусалъя “Хүүхдийн оролцооны үндэсний зөвлөгөөн”, Монголын Хүүхдийн зөвлөлийн “МАЙХАНТ” чуулган, НУНА хайрцаг , “Амжилтын нууц” сэдэвт хэлэлцүүлэг Хүүхдийн зөвлөлийн спорт өдөрлөг, үйл ажиллагаанд нийт 1130 хүүхэд оролцсон байна. Дүүргийн ГБХЗХХ, Цагдаагийн газраас хамтран сэтгэцэд</p>	
--	---	--	--	--	---	--

						<p>нөлөөлөх бодис хэрэглэсэн, хараа хяналтгүй хүүхдүүдэд эргэн хяналт тавих арга хэмжээг 1 удаа зохион байгуулж, 7 хүүхдэд Урлагийн сэтгэл заслын “Мандала терапи” сургалтыг зохион байгуулж хүүхдүүд болон хүүхдүүдийн ар гэрийнхэнтэй уулзаж хүүхдүүдэд тавих хараа хяналтаа сайжруулах зөвлөмж өгч, дүүргийн 7, 8, 9 дүгээр хороонд байрлах хүүхдүүд орж орогнож болзошгүй объектуудыг шалгасан.</p>	
2.5.2	<p>Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дэргэд “Эцэг эхийн зөвлөл” байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх.</p>	<p>Улсын төсөв, ОН төсөв 2.0</p>	<p>Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо</p>	0	20	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дэргэд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт <b>89</b> байгууллага “Эцэг эхийн зөвлөл” байгуулсан байна. Дүүргийн ГБХЗХХ-ээс тус байгууллагуудаас “Эцэг, эхийн зөвлөл”-ийг чадавхжуулах чиглэлээр 2022 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэж, 2022 онд <b>26</b> ажил, арга хэмжээг хийхээр төлөвлөн 2022 оны жилийн эцсийн байдлаар Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт эцэг, эхийн зөвлөл <b>89</b> байгууллага байгуулсан байгууллагын тайланг жилийн эцсийн байдлаар нэгтгэхэд байгууллага тус бүр үйл ажиллагаа зохион байгуулсан ба нийт <b>124</b> ажил <b>450</b> гаруй албан хаагчид оролцоотой ажилласан байна. Мөн Байгууллагын дэргэдэх Нийслэлийн “Тэргүүний эцэг эхийн зөвлөл” шалгаруулах үйл ажиллагаанд дүүргээс <b>25</b> байгууллага материал хүргүүлэн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс шалгарсан байна. 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Байгууллага аж ахуй</p>	90

						<p>нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, эцэг, эхийн зөвлөлийн нийт 75 хүн оролцлоо. Зөвлөгөөнд Гэр бүл судлаач Ж.Баясгалан, Хувь хүний хөгжлийн дасгалжуулагч, көүч, А.Адъяасүрэн нар “Хүүхдийн эрх ба хүүхэд хамгаалалд эцэг эхийн оролцоо”, “Шинэ би-Өөрийгөө таних” сэдвийн хүрээнд сургалт мэдээллийг өгч, эцэг, эхийн зөвлөлүүд хүүхэд хамгааллын чиглэлээр ололт амжилт, туршлагаасаа хуваалцан,цаашид хийж хэрэгжүүлэх ажлын санал санаачилгыг дэвшүүллээ.</p>	
2.5.3	<p>Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулан салбар дундын уялдаа холбоог сайжруулж, дэмжин ажиллах.</p>	<p>Орон нутгийн төсөв 3.0</p>	<p>Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо</p>	4	6	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/39 дүгээр тушаалын дагуу Хамтарсан багийн нарийн бичгийн дарга бөгөөд хороодын Нийгмийн ажилтнуудад “Кейс менежментийн үйлчилгээ үзүүлэх арга зүй”, “Ажлын байрны стресс менежмент” сэдэвт сургалтыг Японы Хүүхдийн Ивээх Сангийн “Хүүхэд хамгааллын арга зүйн төв”-тэй хамтран 2022 оны 03 дугаар сарын 04,11-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 18 нийгмийн ажилтан хамрагдав. Мөн дүүргийн ИТХ-тай хамтран зохион байгуулсан “Нийгмийн ажил-Мэргэжлийн үйлчилгээ” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт хорооны, эрүүл мэндийн, халамжийн, боловсролын салбарын нийт 56 нийгмийн ажилтан тус тус хамрагдсан. Мөн Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Гүүд Нейборс” Олон улсын байгууллагатай хамтран Хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах сургалтад дүүргийн 13,14,15,16,19 дүгээр хороодын Хамтарсан багийн нийт 21 гишүүн, Хамтарсан багийн нарийн бичгийн дарга</p>	90



						<p>нар буюу Нийгмийн ажилтнуудыг чадваржуулах “Нийгмийн ажил ба хүний хөгжил” сургалтад нийт 18 Нийгмийн ажилтан, НАМС программын талаар 3 удаагийн сургалт давхардсан тоогоор 57 Нийгмийн ажилтан, ХНХЯ-аас зохион байгуулсан "Хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил үйлчилгээний арга зүй, кейс менежмент" сэдэвт сургалтад нийт 14 Нийгмийн ажилтан тус тус хамрагдсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/28 дугаар тушаалаар дүүргийн 1-19 дүгээр хороодын Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах шатахуун болон шуудан холбооны зардлыг шийдвэрлэж, Хамтарсан багийн үйл ажиллагаанд <b>13,650,000</b> төгрөгийн дэмжлэг олгож, “Ковид-19” цар тахлын нөхцөлд хүүхэд, гэр бүлд мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл олгосон. Мөн Хамтарсан багийн гишүүдийг ажлын байранд чадваржуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах үйл ажиллагааг хороодод 3 удаа зохион байгуулсан.</p>	
--	--	--	--	--	--	--	--

2.5.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээг хүргэж ажиллах.	-	Үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	20	50	Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээг хүргэж ажиллах зорилгоор Хүүхдийн номын өргөөний номын санч нар харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан брайл үсгэн 20 ном бүтээж, харааны бэрхшээлтэй хүүхэд багачуудад зориулсан CD сонсдог 15ш номоор сан хөмрөгийг баяжуулж, давхардсан тоогоор 30 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд багачуудад үйлчилсэн. Дүүргийн Хүүхдийн номын өргөөний 3 давхарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан булан байгуулж ажилласан.	90
2.5.5	Дүүргийн алслагдсан хороодод “Явуулын номын сангийн үйлчилгээ”-г хүргэж, хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх.	Орон нутгийн төсөв 2.0	Хамрагдсан хүүхдийн тоо	100	200	Дүүргийн алслагдсан гэр хорооллын хүүхдүүдэд номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор дүүргийн 16 дугаар хороонд байрлах Гүүд нейборс Олон улсын байгууллагын “Ботгохон” номын санг дүүргийн Хүүхдийн номын өргөөний харьяанд шилжүүлж авсан. Мөн явуулын номын сангийн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор тус байгууллагын явуулын автобусыг 6 сарын хугацаанд ажиллуулахаар “Хамтран ажиллах гэрээ”-г 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр байгуулж, дүүргийн 117, 149, 50, 138 дугаар сургуулийн 2701 хүүхдэд, дүүргийн алслагдсан 7, 15, 17 дугаар хороодын 85 хүүхдэд “Явуулын номын сан”-гийн үйлчилгээг хүргэсэн ба нийт 2786 хүүхэд багачуудад хүрч ажилласан байна.	100
<b>2.6 ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ</b>							
Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн агуулгыг баяжуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилготой “Соёлтой иргэн-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
2.6.1	Соёл урлаг, спортын тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд	-	Хамрагдсан иргэдийн тоо	-	1000	Ерөнхий боловсролын сурагчдын урлагийн авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх,	100

	<p>зохион байгуулагдах арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, иргэдийн оролцоог ханган ажиллах.</p>				<p>урлаг соёлын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд багачуудыг төлөвшүүлэх зорилгоор дүүргийн “Хүүхдийн урлагийн наадам-2022” арга хэмжээг 2 насны ангилалд 7 төрлөөр зохион байгуулж, Ерөнхий боловсролын 18 сургуулийн 800 гаруй авьяаслаг сурагчид оролцсон. Арга хэмжээг зохион байгуулсны наадмын дүнг гаргаж танилцуулсан ба 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Улаанбаатар театр”-ын урлагийн танхимд “Хүүхдийн урлагийн наадам-2022” наадмын шилдэг үзүүлбэрүүдээр “Гала тоглолт”-ыг зохион байгуулж, 1, 2, 3 дугаар байрт шалгарсан авьяаслаг бяцхан хүүхдүүдийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. “Дээлтэй Монгол-2022” наадам энэ жил 16 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд Монгол орны үндэстэн ястан бүрийн онцлог, түүх соёлыг агуулсан үндэсний хувцастай иргэдийн баярын жагсаалд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-24 дүгээр хороодын 1000 орчим иргэдийн төлөөлөл энэхүү наадамд үндэстэн ястны дээлээр гоёж оролцож, дүүрэг 2 дугаар байрт шалгарсан ба мөн дүүргийн 18 дугаар хорооны Засаг дарга Л.Бат-Оргил “Шилдэг урлаач” төрөлд тэргүүн байр эзэлсэн. Нүүдэлчин иргэдийн амьдралын өвөрмөц төрх, зан үйл, хөгжил дэвшлийн нэгэн илэрхийлэл болсон соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилго бүхий “Нүүдэлчин Монгол-2022” наадмыг 2022 оны 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулсан ба дүүргийн шилдэг 17 өвлөн уламжлагчдыг хамруулан 7 төрөл бүхий</p>	
--	---	--	--	--	---	--

					<p>зан үйлийн үзүүлбэр, язгуур урлагийн тоглолт, гар урлалын үзэсгэлэн, соёлын биет бус өвийг таниулан сурталчлах арга хэмжээ, уралдаан, тэмцээн, соёлын бүтээлч үйлдвэрлэл, үзэсгэлэн худалдаа, соёлын биет бус өвийг иргэд, жуулчдад таниулан сурталчилж ажилласан. “Хотын соёл-Хариуцлагатай иргэн” аяныг нийслэлийн Чингэлтэй дүүргийн 15-19 дүгээр хороодод хуваарийн дагуу зохион байгуулж 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд дүүргийн Соёлын төвийн дэргэдэх “Ахмадын дөрвөн цаг” хамтлагийн тоглолтыг 600 гаруй иргэдэд хүргэж ажилласан. Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, өсвөр үеийнхэнд урлаг, уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг” шалгаруулах уралдаант наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, уралдаанд дүүргийн ерөнхий боловсролын 9 сургуулийн, 500 гаруй хүүхэд багачууд оролцсоноос нэгдүгээр байранд Нийслэлийн Ерөнхий боловсролын 17 дугаар сургууль хоёр дугаар байранд Нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль, гуравдугаар байранд Нийслэлийн Ерөнхий боловсролын 37 дугаар сургууль тус тус шалгарсан. Дүүргийн хороодын иргэдийн</p>	
--	--	--	--	--	--	--

						дунд зохион байгуулах “Нийтийн бүжгийн шилдэг хос” шалгаруулах тэмцээнийг 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр дүүргийн Биеийн тамир, спортын хорооны урлагийн танхимд зохион байгуулж, 30 гаруй иргэнийг хамруулсан.	
<b>2.7 ЖЕНДЕР</b>							
Жендерийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, Жендерийн салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлнэ.							
2.7.1	Жендерийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ажилтан албан хаагчдыг жендерийн боловсрол олгох сургалтад хамруулах.	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын хувь	15%	30%	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан “Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ” сэдэвт онлайн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулж 1668 албан хаагч цахим сертификатын сургалтад хамрагдаж, сертификат авсан. Сертификат батламж авсан албан хаагчдын мэдээлэл, сертификатын хуулбарыг хавсарган илтгэх хуудсаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. Жендерийн үндэсний хорооноос Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээний “Харилцан хүндэтгэе” аяныг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 1 сарын хугацаатай зохион байгуулах удирдамж, чиглэлийн хүрээнд “Харилцан хүндэтгэе”, “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилъе, хамтдаа үлгэрлэе” урианы дор зохион байгуулж жендерийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтаас ангид байх нийгмийн сэтгэлгээг бий болгоход чиглэсэн үйл	90

						ажиллагаануудыг зохион байгуулж ажиллахыг 1-19 хороод, ЗД-ын дэргэдэх 22 хэлтэс албадад үүрэг чиглэл болгон албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүжилттэй жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх “Олон нийтэд суурилсан зан үйлийг өөрчлөх харилцааны цогц загвар” төслийн хүрээнд сургууль, хамт олон, медальд суурилсан аргачлалын туршилтын үр дүнд боловсруулсан “Нийгэм зан үйлийг өөрчлөх цогц загвар” арга зүйг танилцуулах цахим сургалтад ЗДТГ-ын 1 албан хаагчийг хамруулсан.	
--	--	--	--	--	--	--	--

**ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

**3.1 САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Монгол улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн биеэ даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.

3.1.1	Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил, тод нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	Улс, нийслэл, орон нутгийн сарын дундаж биелэлт 70.5%, өссөн дүнгээ рээ дундаж биелэлт	Орлогын төлөвлөгөө 85-аас дээш хувиар биелсэн байх.	Чингэлтэй дүүргийн төсвийн орлогын 04 дүгээр улирлын төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар авч үзвэл: -Улсын төсөвт 41.130.1 сая төгрөг төвлөрөхөөс 42.387.5 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 103.06%-тай төвлөрсөн. -Нийслэлийн төсөвт 86.953.4 сая төгрөг төвлөрөхөөс 67.665.2 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 77.8%-тай төвлөрүүлсэн. -Орон нутгийн төсөвт 136 848.7 сая төгрөг төвлөрөхөөс 124 520.9 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө хувиар тус тус биелэлттэй гарч, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн	90
-------	--	---	-------------------------------------	--	---	---	----

				99.21% байна.		биелэлтийг хангахад хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож, орлогоороо зарлагаа нөхөн бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	
Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийж, зардал бууруулах, төсвийн сахилга хариуцлага, дүүргийн төсвийн байгууллагуудын орлого, зарлага, хөрөнгө оруулалтын ажил болон хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.							
3.1.2	Төсвийг төлөвлөх, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад төсвийн тогтвортой, иж бүрэн, үнэн зөв, ил тод, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх зарчмуудыг мөрдлөг болгон ажиллаж, төсөвт байгууллагын төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, урсгал зардалд дүн шинжилгээ хийж, төсвийн үр өгөөжийг сайжруулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	2021 онд үргүй зардлыг 0.1 хувиар багасга-сан.	Төсвийн үргүй зардлыг 0.05 – 0.2 хувиар багасгах.	Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, Дүүргийн Засаг даргын 2022 оны “Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах” тухай А/45 дугаар захирамжийг 2022 оны 4/246 тоот албан бичгээр, үр өгөөж сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлийг 2022 оны 4/1707 тоот албан бичгээр Татварын хэлтэс болон харьяа 67 байгууллагын төсвийн шууд захирагч нарт хүргүүлж, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан. Нийт байгууллагуудын бүлэг хоорондын болон сар хоорондын төсөвт зохицуулалт хийх тухай саналыг судлан, дүүргийн Засаг даргын 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн А/68, 3 дугаар сарын 23-ны өдрийн А/107, 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/153, 5 дугаар сарын 10-ны өдрийн А/171, 6 дугаар сарын 3-ны өдрийн А/202 дугаар, 10 дугаар сарын 28-ны А/330 дугаар захирамжаар төсөвт өр авлага үүсгэхгүй, зохистой удирдлага хэрэгжүүлэх үүднээс орон нутгийн төсвийн зарлага, сургууль цэцэрлэгийн төсвийн хуваарьт тус тус өөрчлөлт оруулав. Дүүргийн татварын орлогыг нэр төрлөөр дүүргийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэх, төсвийн байгууллагуудын харилцах дансанд орсон орлогыг тухай бүр холбогдох эдийн засгийн ангилалд бүртгэх, сарын мэдээний өр авлагыг бүртгэх ажлыг тус тус журнал ваучераар тухай бүр төрийн сангийн	90

						программд бүртгэн ажилласан. Орон нутгийн болон төсөвт байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээг өөрчлөлт оруулсан төсвийн хуваарь, санхүүжилтийн багцын олгосон эрхийн дагуу цаг хугацаанд хөнгөн шуурхай бүрэн эрсдэлгүй хянан гүйцэтгэж ажилласан.	
3.1.3	Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд төсвийн захирагч нарт мэдээлэл хүргэх, санхүү бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт семинарыг цахим болон танхим хэлбэрээр зохион байгуулах, мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх.	Дүүргийн төсөв 20.0	Сургалт, хамрагдсан хүний тоогоор	4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 222 нягтлан бодогчийг хамруулсан.	5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 250-аас дээш тооны албан хаагчийг хамруулсан байх.	Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагуудын төсвийн шууд захирагч болон санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах 2022 оны нэгдсэн сургалтын төлөвлөгөөг батлуулан ажиллан, 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 269 санхүүгийн албан хаагчид болон төсвийн шууд захирагч нар хамрагдсан.	90
3.1.4	Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> сайт, дүүргийн цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан санхүү, төрийн сангийн үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх, төсөвт байгууллагуудын төсөв санхүүгийн мэдээг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээлэхэд хяналт тавьж ажиллах.	-	Цахим сайтад байршуулсан мэдээний тоо	17 төрлийн мэдээ	17 төрлийн мэдээ	Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд сар бүрийн 08-ны өдрийн дотор Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ зэрэг 17 төрлийн хугацаат мэдээллийг 1-11 дүгээр сард Монгол Улсын Сангийн яамны “Шилэн данс”-ны нэгдсэн <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд тухай бүр гүйцэтгэлийг байршуулж мэдээлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Хөрөнгө оруулалтын 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ болон 2021 оны жилийн эцсийн аудитын тайлангийн биелэлтийг байршуулан ажилласан. Чингэлтэй дүүргийн “Шилэн	100



						дансны мэдээлэл” самбарт байрлах тоон мэдээллийг сар бүр тогтмол баяжуулж, иргэд, олон нийтэд мэдээллийн ил тод, нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй байдлыг ханган ажилласан.2022 оны Хот тохижилтын дансны гэрэлтүүлэг, хог тээвэрлэлтийн зардлын шилэн дансны 2022 онд 131 мэдээллийг нөхөн оруулсан.	
<b>3.2. ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ</b>							
Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүнс, худалдаа үйлчилгээ, барилга, эрүүл мэнд, боловсролын салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэнэ.							
3.2.1	Худалдаа, нийтийн хоолны салбарт тавигдах стандартын хэрэгжилтийг хангуулж, хяналт шалгалт, мэргэжил арга зүйн удирдлагаар байгууллагуудыг хангаж ажиллах.	Дүүргийн төсөв 2.0	Хоолны газруудын үйл ажиллагаанд тавих хяналт сайжирна	80 %	90%	1.Улаанбаатар хотын Захирагчийн албаны 01/3184 тоот албан бичиг, дүүргийн Засаг даргын А/52 дугаар захирамжийн дагуу дүүргийн 1 дүгээр хороо, Ард кино театрын автобусны буудал, Мөнгөн завьяа дэлгүүрийн автобусны буудал, 4 дүгээр хороо, Анкарагийн гудамжны автобусны буудал дээрх 6 ТҮЦ-нд хяналт шалгалт хийж, нийтийн эзэмшлийн гудамж талбайд зөвшөөрөлгүйгээр байршуулсан ТҮЦ-ийг нүүлгэн шилжүүлж, холбогдох арга хэмжээ авч хамтран ажиллах талаар дүүрэг дэх Газар зохион байгуулалтын албанд албан бичиг хүргүүлэн ажилласан.  2.Дүүргийн Засаг даргын 2022 оны А/53 дугаар захирамжийн хүрээнд хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, өсөж хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэднийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран дүүргийн 1-6 дугаар хорооны төрийн ба төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн ойр орчимд байрлах 42 хүнсний дэлгүүрүүдэд Хэрэглэгчийн эрхийг	90

					<p>хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.</p> <p>3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Сайдын 2022 оны А/20 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамж болон Чингэлтэй дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу нийслэлийн хүн амыг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах зорилгоор “Архангайн цагаан идээ” үзэсгэлэн худалдааг дүүргийн 5 дугаар хороо, Тусгаар тогтнолын талбайд 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 31-ний өдрүүдэд зохион байгуулж, сүү, цагаан идээг иргэдэд дундын зуучлагчгүйгээр худалдан борлуулж ажилласан. Үзэсгэлэн худалдаанд Архангай аймгийн 8 сумын 34 малчид, үйлдвэрлэгчдийн өөрсдийн гараар боловсруулсан (сүү 3451 кг, сүүн аарц 68 кг, ааруул 8840 кг, аарц 2711 кг, зөөхий 697 кг, өрөм 1662 кг, хайлмаг 187 кг, цагаан тос 34 кг, шар тос 1088 кг, эззгий 204 кг, шимийн архи 340 литр) 11 нэр төрлийн 20.1 тн бүхий 322.8 сая төгрөгийн цагаан идээг худалдаалж нийслэлийн хүн амын хэрэгцээг хангасан байна. Үзэсгэлэн худалдаанд оролцож байгаа малчид, иргэдийн халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн, аюулгүй байдлыг сахиулах үүднээс “Санамж бичиг”-ийг худалдаа эрхлэгчидтэй байгуулж, нэгдсэн хаягаар жигдрүүлэн, талбайн цахилгаан хангамж, хог хаягдал, ариун цэврийн асуудлыг үнэ</p>	
--	--	--	--	--	---	--

						төлбөргүйгээр шийдвэрлэн малчдаа дэмжин ажиллалаа.	
3.2.2	“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн тариаланчдыг төмс, хүнсний ногооны хөнгөлөлттэй үнээр ханган ажиллах.	-	Хамрагдсан иргэний тоогоор	150 иргэн	200 иргэн	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 03/112 дугаартай албан бичгээр хаврын тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд 80%-н хөнгөлөлттэй үнээр олгох 10 төрлийн хүнсний ногооны үрийн нийт үнэ болох 203,847 төгрөгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын бараа үйлчилгээний бусад зардлаас гарган хүсэлтээ ирүүлсэн 22 хорооны 241 иргэн, аж ахуйн нэгжийн хүнсний ногоо, газар тариалан эрхлэгчдэд 11,7 кг үрийг үнэ төлбөргүйгээр олгох ажлыг зохион байгуулан ажиллалаа. Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газраас 80%-н хөнгөлөлттэй үнээр олгосон 50 кг нийт 99,800 төгрөгийн төл сонгинын үрийг дүүргийн 12 хорооны 12 иргэнд  тарааж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажилласан.	90
3.2.3	Шинэ ургацын төмс, хүнсний ногоо, худалдан борлуулах, мод үр үрслэгээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, тариаланч иргэдийг дэмжин ажиллах.	-	Хамрагдсан иргэний тоогоор	90 иргэн	100 иргэн	1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” 58 дугаар зарлиг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/496 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 01/447 дугаар албан бичиг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/102 дугаар тушаал, 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/238 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулахаар дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачдын талбайд 4 болон 10 дугаар	100

					<p>саруудад “Мод, бут сөөг, үр үрслэгээний үзэсгэлэн худалдаа-2022” арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үзэсгэлэн худалдаанд 30 иргэн, 18 аж ахуйн нэгж оролцож, шилмүүст болон навчит, гоёлын бут сөөг, үрсэлгээ, тасалгааны болон мандлын цэцгийн үрсэлгээ, ногооны үр зэрэг 100 гаруй нэр төрлийн 6000 ширхэг мод бут, сөөг худалдаалагдаж, 130 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.</p> <p>2. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдааг зохион байгуулах тухай” А/138 дугаар тушаалаар “Алтан намар” арга хэмжээний хүрээнд төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах байршил, мөрдөх түр заавар батлагдсан. Тушаалын дагуу дүүргийн 2 дугаар хороо, Эрдэнэбулган ХХК-ийн Содон бөмбөгөр худалдааны төвд 10 асар, Алтжин бөмбөгөр төвд 3 асар, 5 дугаар хороо Тусгаар тогтнолын талбайд 45 асар, 20 дугаар хороо Зунжин бүсэд 2 асар нийт 60 иргэн, аж ахуйн нэгж 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд эх орны хөрсөнд ургасан 23 нэр төрлийн төмс, хүнсний ногоог гадна талбайд асарт худалдаалж Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангасан байна. Тус үзэсгэлэн худалдаагаар 23 нэр төрлийн хүнсний ногоо борлуулж 910 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон байна. Худалдаа эрхлэгч нарыг нэгдсэн хаягаар жигдрүүлж, мандат олгож, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Татварын</p>
--	--	--	--	--	---

						<p>хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулж, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж өгч, гарал үүслийн гэрчилгээтэй, жин хэмжүүрийн баталгаатай худалдаа үйлчилгээ эрхлэх санамж бичиг байгуулан ажилласан.</p> <p>3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зохион байгуулж буй “Намрын ногоон өдрүүд-2022” арга хэмжээний хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэнд дүүргийн худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн 5 аж ахуйн нэгжийг хамруулан ажиллалаа.</p>	
3.2.4	<p>Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуй нэгжид холбогдох дүрэм, журам мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт, шалгалт зохион байгуулж сургалтад хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах.</p>	<p>Дүүргийн төсөв 1.0</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар</p>	80%	90%	<p>Дүүргийн 12, 14, 15, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийт 75 авто үйлчилгээ, дугуй засвар, сэлбэг худалдаа, барилгын материал худалдаалах цэгийн үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, хороодын ажлын алба, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багийн бүрэлдэхүүнтэй 2022 оны 04 дүгээр сарын 20, 26-ны өдрүүд, 05 дугаар сарын 28, 30-ны өдрүүдэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтад хамрагдсан хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 20 авто үйлчилгээ, дугуй засвар, сэлбэг худалдаа, барилгын материал худалдаалах цэгүүд нь нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний орц, гарц замыг хааж үйл ажиллагаа явуулсан зөрчлийг газар дээр нь арилгуулж ажиллалаа. Дүүргийн 14 дүгээр хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багийн гишүүдтэй уулзаж үүрэг чиглэл өгч, зөрчил гаргасан</p>	90

						иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд батлагдсан хуваарийн дагуу хяналт тавьж тайлан мэдээг авч ажиллаж байна.	
3.2.5	Жижиг дунд, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, борлуулалтыг дэмжих видео контент хийн олон нийтэд түгээх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	-	100%	Үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 50 үйлдвэрлэл эрхлэгчдийн 411 бүтээгдэхүүнийг хамруулан видео контент бэлтгэж үндэсний худалдаа үйлдвэрлэл ЧД-н Бизнес инкубатор төв “Чингэлтэйд үйлдвэрлэв” цахим сүлжээ хаягуудыг ашиглан олон нийтэд сурталчлан ажилласнаар давхардсан тоогоор 120,612 хандалт авч, 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гарагт тогтмол мэдээг байгууллагын цахим хаягт болон бусад цахим сүлжээнд байршуулан түгээн сурталчлан ажиллаж байна.	100

### 3.3 БАРИЛГА ХОТ, БАЙГУУЛАЛТ

Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж нэгдсэн удирдлага-хяналтын системд холбож, “Жишиг гудамж”-ны тоог гэр хороололд нэмэгдүүлнэ.

3.3.1	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.	Улсын төсөв 240.0	Гэрэлтүүлгийн тоо	11228	11428	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хустайн шил” ХХК 16, 17 дугаар хороодод 222 гэрэлтүүлэг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд Хайлаастын авто замын гэрэлтүүлэг хийхээр “Өндрийн удам” ХХК шалгарч 46 гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийн хамт хийж гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд 7, 12, 16, 17 дугаар хороонд хийгдэх 125 гэрэлтүүлгийн зураг, төсвийн ажлыг “Жэй Ди Эй” ХХК хийж гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлж тендер зарлагдсан. Тендер 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр нээгдэнэ. Дүүргийн 1-6, 8, 11, 13, 14,	90
-------	---	-------------------	-------------------	-------	-------	---	----

						18 дугаар хороонд хийгдэх 48 гэрэлтүүлгийг “Соёндрийм” ХХК хийж гүйцэтгэсэн.	
3.3.2	“Жишиг гудамж”-ны тоог гэр хороололд нэмэгдүүлэх.	Улсын төсөв 1,000.0	Жишиг гудамжны тоо	15	18	Дүүргийн 14 дүгээр хороонд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Гудамжны тохижилт, шинэчлэл” төсөл арга хэмжээний хүрээнд Хайлаастын 11 дүгээр гудамжинд байгалийн чулуун зам, явган зам, хашаа шинэчлэн засварласан хашаа бүхий жишиг гудамжны тохижилтын ажил хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгөөр 12 байршилд бетонон зам, байгалийн чулуун зам, хашаа шинэчлэх, зогсоол хийх зэрэг ажлууд төлөвлөгдөн ажлын даалгавар гаргуулж тендер зарлан Трайзинг ХХК шалгаран 12 дугаар хороонд бичил цэцэрлэг, 16 дугаар хороонд 1621 эко хавтан, 19 дүгээр хороонд 405м2 бетонон зогсоол, 2110м2 явган замыг тус тус хийж гүйцэтгэлээ.	90
Үерийн далан суваг, борооны ус болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, сэргээн засварлах, гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган зам, шат, гүүр барьж иргэдийн амьдрах орчныг сайжруулна.							
3.3.3	Үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг шинээр барьж, өргөтгөн шинэчилж, сэргээн засварлах.	/НОНХС/ 460.0	Нэмэгдсэн хувь	11,9 км	0.6%-р нэмэгдүүлэх	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар “138 дугаар бага сургууль, 220 дугаар цэцэрлэгийн барилгын гадна түшиц хана, гадна талбайн засвар, үерийн хамгаалалтын шугам” төсөл арга хэмжээг “Модерн хас” ХХК хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд 198 у/м үерийн хамгаалалтын шугам сүлжээний ажил 100% хийгдсэн. Геодези, Усны барилга байгууламжийн газартай хамтран тус дүүргийн 12 дугаар хороо, 61 дүгээр сургууль орчимд 198 у/м хөрсний ус зайлуулах шугам, ус хүлээн авах шүүрт худаг 6ш, үзлэгийн худаг 8ш тус тус хийгдсэн. Дүүргийн 19 дүгээр хороо, доод	90

						Салхитад 259 у/м хөрсний ус зайлуулах шугам угсралт болон шугам угсралтын дараах нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажил” төсөл, арга хэмжээг “Вектор ус дриллинг” ХХК хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэл 90%-тай байна. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Гүн нуур ХХК-ны арын жалга, Хайлаастын гудамжинд далан барих” төсөл, арга хэмжээг “Вектор ус дриллинг” ХХК хэрэгжүүлэн газар шорооны ажил, хоолой тавих ажил, хавтан суурилуулах ажил 60%-н гүйцэтгэлтэй байна.	
3.3.4	Гэр хороодын гуу жалга бүхий газруудад шат, гүүрэн байгууламж барих, сэргээн засварлах.	Улс, Нийслэл, Дүүргийн төсөв	Гүүр, шатны тоо	57 гүүр 21 шат	1 гүүр 1 шат	Дүүргийн төсвийн урсгал зардлаар 15 дугаар хорооны нутаг дэвсгэрийн гуу жалга бүхий газарт 8 у/м шат хийх ажлыг Чингэлтэй дүүргийн Төхижилт үйлчилгээ ХХК-р гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100%-тай байна. Мөн дүүргийн 19 дүгээр хороо, 117 дугаар ерөнхий боловсролын сургуулийн зүүн талд Сэлбэ гол дээр байрлах явган хүний гүүрэн байгууламж, 17 дугаар хороо Сурагчийн 50 дугаар гудамжны явган хүний гүүрэн байгууламж, 20 дугаар хороо Хувьсгалчдын Г-11 дүгээр гудамжны гүүрэн байгууламжийн эвдрэлийг Чингэлтэй дүүргийн “Төхижилт үйлчилгээ” ХХК-р тус тус засварлуулж хэвийн ажиллагаанд оруулсан.	90
Орон сууц, гэр хорооллын дунд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, бичил цэцэрлэг, явган болон дугуйн зам барьж, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлнэ.							



3.3.5	Орон сууц, гэр хорооллын дунд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, бичил цэцэрлэг, явган болон дугуйн зам барьж, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх.	Улс, Нийслэл, Дүүргийн төсөв 150.0	Нэмэгдүүлсэн тоо	61	65	<p>Ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хороо Тахилтын аманд 4 тэрбум төгрөгийн тохижилтын ажлын зураг төсвийг “Сивил дизайн” ХХК хийж гүйцэтгэн тендер зарлан, гүйцэтгэгчээр “Жавхлан хүслэн” ХХК шалгаран газар шорооны ажлыг эхлүүлсэн.</p> <p>Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3 дугаар хороонд 200м<sup>2</sup> явган зам, 135м<sup>2</sup> зүлэг, 1 сүүдрэвч, 7 дугаар хороонд жишиг 3*3 сагсан бөмбөгийн стандарт талбай тус тус хийж гүйцэтгээд байна.</p> <p>Дүүргийн 8 дугаар хороонд 240 у/м явган замыг “Монгол туургатны зам” ХХК хийж гүйцэтгэсэн.</p> <p>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороонд сагсны болон хүүхдийн тоглоомын талбайг “Би Жи Роял” ХХК хийж гүйцэтгэсэн.</p> <p>Орон сууц болон гэр хорооллын дунд 6 байршилд хүүхдийн тоглоомын талбайг засварлах ажлын зураг төсвийг “Түвшин тумбааш” ХХК хийж гүйцэтгэн тендерийн сонгон шалгаруулалтыг зарласан. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 144 гарааш буулгаж байршилд тохижилтын ажил хийж гүйцэтгэсэн.</p>	90
Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, автозамын дэд бүтцийг сайжруулна.							
3.3.6	Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, автозамын дэд бүтцийг сайжруулах.	Улс, Нийслэл, Дүүргийн төсөв 2,500.0	Нэмэгдүүлсэн тоо	144.6	147.1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 11, 13, 14, 15, 17, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт "Гудамжны тохижилт, шинэчлэл", "Жишиг гудамж", "Хорооны доторх авто зам", "Хорооллын доторх авто зам" төсөл арга хэмжээнүүд хэрэгжиж 1256 у/м авто зам шинээр тавигдсан.	90

						<p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тус дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт “138 дугаар бага сургууль, 220 дугаар цэцэрлэг явах авто зам” төсөл арга хэмжээ хэрэгжиж 210 у/м авто зам шинээр тавигдсан.</p> <p>Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10, 11, 12, 14, 15, 16, 17, 18, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт “Гудамж сайжруулах” төсөл арга хэмжээний хүрээнд 1391 у/м авто зам шинээр тавигдсан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт</p> <p>“17 дугаар хорооны Сурагчийн 24-р гудамж авто зам, чулуун зам тавих” төсөл арга хэмжээ хэрэгжиж 150 у/м авто зам шинээр тавигдсан. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 233 у/м авто зам шинээр тавигдсан. Дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэл, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөв, дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр нийт 3240 у/м авто зам шинээр тавигдаж, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-аас 4030 у/м авто замын засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	
Эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг цахилгаанаар хангах ажлыг үе шаттай судалж, хэрэгжүүлнэ.							
3.3.7	Эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг цахилгаанаар хангах ажлыг судалж,	Улс, Нийслэл, Дүүргийн төсөв	Айл өрхийн тоо	4743 айл өрх	100 айл өрх	Тус дүүргийн 2 дугаар хорооны ҮХ-12 дугаар байрны дахин төлөвлөлттэй холбоотойгоор “Мон-Тед констракшн” ХХК нь цахилгаан дамжуулах ХТП-118 дэд өртөө /ХТП-118 дэд өртөөг 1960 онд	70

<p>мэргэжлийн хамтран хэрэгжүүлэх.</p>	<p>байгууллагатай үе шаттай</p>				<p>ашиглалтад оруулсан, ашиглалтын хугацаа дууссан/-ний барилга, тоноглолыг бүрэн шинэчлэн барих ажлын хүрээнд 630 кВА цахилгаан дамжуулах тэжээлийг 800 кВА болгон өргөтгөн шинэчилж цахилгаан эрчим хүчний хүчдэлийн уналтыг бууруулсан. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв нь төлөвлөгөөт урсгал засварын ажлын хүрээнд дүүргийн 17, 18, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт 3500 гаруй айл өрхүүдийн тоолуурын нэгдсэн нийт 645 хайрцагт ашиглалт, битүүмжлэл сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 115 байршил буюу 25 фидерийн 62 дэд өртөөний 115 тоолуурын нэгдсэн хайрцагт өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэж хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний найдвартай хэрэглээг хангах нөхцөл тодорхой хэмжээнд бүрдсэн. Мөн хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчний хангамжид шинээр холбох нөхцөл бүрдүүлсэн.Цахилгаан эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийн судалгааг 7-19 /хуучнаар/ дүгээр хороодоос 2022 оны байдлаар шинэчлэн авч нэгтгэсэн. Тус судалгаагаар нэгтгэсэн нийт 580 айл өрхийн мэдээллийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д 2/2286 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн тус дүүргийн 17, 18 дугаар хороодын иргэдийн хүсэлтийн дагуу айл өрхүүдийн цахилгаан эрчим хүчний уналтыг бууруулах зорилгоор УБЦТС ТӨХК-ийн</p>	
--	---------------------------------	--	--	--	---	--

						Зүүн түгээх төвд 3/1283 тоот албан бичиг хүргүүлсэн.	
<b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО /БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД/</b>							
<b>4.1. МЭРГЭШСЭН, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА</b>							
4.1.1	Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг болон Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг Дүүргийн цахим хуудсанд байршуулах.	-	Мэдээний тоо	13	15	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд дүүргийн <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэд сул орон тооны зарыг 3 удаа, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн зөвлөл, Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээ, байгууллагын 2022 онд зохион байгуулагдах сургалтын нэгдсэн төлөвлөгөө, тангараг өргөсөн албан хаагчдын нэрсийн жагсаалт, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгосон албан хаагчдын нэрсийн жагсаалт, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам, Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын ажлын үнэлсэн байдал зэрэг нийт 12 мэдээг байрлуулж ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/204 дүгээр тушаалаар байгуулагдсан Ёс зүйн зөвлөл, Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг дүүргийн <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим хуудсанд байршуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлуулж ажилласан.	90

4.1.2	Хүний нөөцийг хөгжүүлж, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах.	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	1064	1300	Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт, хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж суралцагч байгууллага болох чиглэлийн хүрээнд Дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулж 34 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 1013 албан хаагч хамрагдсан.	90
4.1.3	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, “Хүний нөөц, нийгмийн баталгаа 2024” арга хэмжээнд хамрагдуулан ажиллах.	-	Батлагдсан хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын	18	20	2022 оны байдлаар гэр бүлийн гишүүний эмчилгээний зардалд 8 албан хаагчид 16,601,843 төгрөг, сургалтын төлбөрт 4 албан хаагчид 9,871,878 төгрөг, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд 2 албан хаагчид 8,500,000 төгрөг зарцуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын хүрээнд эмчилгээний зардалд 1 албан хаагчид 420,000 төгрөг, шинээр гэр бүл болж, гэрлэлтээ батлуулсан 5 албан хаагчид 3,797,616 төгрөг, гэр бүл, төрөл садны хүн нас барахад 10 албан хаагчид 9,820,000 төгрөг, цэргийн цол ахисан 1 албан хаагчид 901,798 төгрөг, амаржсан 3 албан хаагчид 2,201,037 төгрөг, урт хугацаагаар гадаадын оронд суралцах болсон 1 албан хаагчид 650,846 төгрөг буюу нийт 11 албан хаагчид 7,871,159 төгрөгийн буцалтгүй тусламж олгон “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээнд хамруулж, нийт 59,569,803 төгрөгийг зарцуулсан. Мөн нийт 6 албан хаагчийн нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэхээр гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.	90
4.1.4	Дүүргийн 30 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх	-	1-19 дүгээр хороодод 19	0	20	Дүүргийн 30 жилийн ойн арга хэмжээний хүрээнд хороодод 49 ажлыг зохион	70

	ажлын хүрээнд 1-19 дүгээр хороодод хийгдэх бүтээлч ажлын саналыг нэгтгэн удирдлагад танилцуулан хэрэгжилтэд хяналт тавих.		бүтээлч ажлууд хийгдсэн байна			байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан. Үүнд: Дүүргийн 4-р хороо: Хорооны зорилтод бүлгийн 30 өрхөд 03 дугаар сарын 07-ны өдөр “Гэр бүлдээ-Бүх хайраа” өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан. Мөн хорооны ажилтан, албан хаагчдын дунд “Дүүргээ хэн сайн мэдэх бэ” асуулт хариултын АХА тэмцээнийг зохион байгуулсан. Дүүргийн 9-р хороо: Хорооны аварга шалгаруулах 4 төрөлт тэмцээнийг 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулан 60 иргэн оролцуулсан.	
4.1.5	Дүүргийн архив болон хөмрөг үүсгэгч байгууллагын 2021 оны архивын баримтын тоон мэдээгээр улсын тоо бүртгэл, мэдээллийн нэгдсэн <a href="http://burtgel.archives.gov.mn">burtgel.archives.gov.mn</a> системд баяжуулалт хийх.		100 хувь хийсэн байна	104 байгууллага	100 хувь оруулах	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Харьяа Нийт 104 байгууллагад Edoc.ulaanbaatar.mn нэгдсэн системээр нийт 42368 албан бичиг ирснээс Хариутай-3991, Хариугүй-38377, үүнээс хугацаандаа шийдвэрлэсэн-40740, хугацаа хоцроож шийдвэрлэсэн 600, судлагдаж байгаа-1023, зөрчил тооцогдсон-362, хугацаа сунгуулсан-55 албан бичиг, шийдвэрлэлтийн дундаж хоног 7.09 /хоногоор/ байна. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудад ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийн тайланг улирал бүр гаргаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж, дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын даргад танилцуулж байна. Тайлант хугацаанд хугацаа хоцорч шийдвэрлэсэн 600 зөрчил тооцогдсон байна.	100
4.1.6	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын нэгдсэн			2500	3000	Дүүргийн хэмжээний ирсэн албан бичгийн нэгдсэн тайлангаар илэрсэн зөрчлийн мэдээг Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба,	90

	систем дэх албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж зөрчлийг бууруулах.	-	Шийдвэрлэлт хяналт тавьсан Албан бичгийн тоо			хороо, сургууль, цэцэрлэгийн удирдлагад “Зөрчил арилгаж, ажлын хариуцлагыг сайжруулах тухай” 2/897, 2/898, 2/899, 2/900, 2/901, 2/902 тоот албан бичиг тус тус хүргүүлсэн. Харьцуулалтын нэгдсэн тайлангаар удаа дараа хугацаа хэтрүүлэн, зөрчил тооцогдсон нийт 10 байгууллагад холбогдох арга хэмжээ авах санал, дүгнэлтийг Нийслэлийн архивын газарт 07 сарын 06-ны өдөр 3/1730 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу НАГ-ын Улсын байцаагчийн албан шаардлага ирүүлснийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 1, 2, 3 дугаар улирлын харьцуулалтын нэгдсэн тайлангаар хугацаа хэтрүүлэн, зөрчил тооцогдсон нийт 60 байгууллагад “Зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцох тухай”, “Хариуцлага тооцож хариу ирүүлэх тухай” 1/2521, 1/2583,1/2590, 1/2591 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн.	
4.1.7	Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллагуудын албан хаагчдад Архив, бичиг хэргийн нэгдсэн сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах.	-	Зохион байгуулсан сургалтын тоо	20	8	Нийт 277 байгууллагын 418 албан хаагчдад 15 удаагийн сургалтыг зохион байгуулсан. <u>Төлөвлөгөөт сургалт:</u> Нийслэлийн архивын газартай хамтран архив, албан хэрэг хөтлөлтийн багц сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад дүүргийн 19 хороодын Засаг дарга, зохион байгуулагч, Засаг даргын эрхлэх хүрээний харьяа байгууллагын удирдлагууд, нэгжийн дарга, архив, бичиг хэрэг хариуцсан албан хаагч, нийт 101 байгууллагын 240 албан хаагчид оролцсон. <u>Цахим сургалт:</u> “Захирамжлалын баримт бичгийг “Archive eDoc” системд оруулах ажлын дараалал”, “Хэвлэмэл хуудасны	100

						<p>нэршил, хаягийн бичвэр өөрчлөх, нэгдсэн мэдээлэл олгох” сэдэвт сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр цахимаар зохион байгуулж 83 байгууллагын 83 албан хаагчид тус тус хамрагдсан.</p> <p><u>Албан хаагчдыг ажлын байран дээр дадлагажуулах сургалт:</u> Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ажлын байран дээр дадлагажуулах сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 17-ны өдрийн хороонд хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, сургууль, цэцэрлэг, УТҮГ, ОНӨТҮГ зэрэг нийт <b>93</b> байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан <b>95</b> албан хаагчдад 13 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p>	
4.1.8	<p>Төрийн дээд одон медаль, Засгийн газар, яамдын шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, материалыг холбогдох дээд байгууллагад уламжлах.</p>	-	Шагнуулсан иргэдийн тоо	438	500	<p>1.Төрийн дээд одон, медаль Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хороодоос Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлж шаардлага хангасан 739 албан хаагч, иргэдийн холбогдох баримтын бүрдлийг хүлээн авч Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт уламжлан google drive программд нэр дэвшигчдийн мэдээллийг бүрэн шивж оруулсан.</p> <p>2.Дүүргийн хэмжээнд 2022 онд “Алдарт эх”-ийн I дүгээр зэргийн одонгоор 34, II дугаар зэргийн одонгоор 467 нийт 501 эх болзол хангасан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх</p>	100



						<p>бүхий албан тушаалтны жагсаалт”-ын дагуу дүүргийн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжээс Засгийн газрын болон яамдын шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамд 72, Барилга, хот байгуулалтын яамд 5, Зам тээврийн яамд 4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 8, Нийслэлийн Соёл Урлагийн газарт 2, Эрчим хүчний яаманд 1, Сангийн яаманд 45, Биеийн тамир, спорт хороонд 1, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 39, Нийслэлийн Боловсролын газарт 2 материалыг дүүргийн Засаг даргын дэмжих бичгүүдээр тус тус уламжилсан. Үүнээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 40, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 5, Нийслэлийн Соёл Урлагийн газраас 2 шагналуудыг хүлээн авч гардуулан өгсөн.</p> <p>Монгол Улсын Сангийн яамны шагналын программ /reward.mkf.gov.mn/ 45, Барилга, хот байгуулалтын яамны шагналын программд 5, Зам тээврийн яамд программд 4 ажилтан, иргэний материалыг оруулан бүртгэж баталгаажуулсан.</p>	
4.1.9	Дүүргийн Засаг даргын шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, материалыг хүлээн авч журмын дагуу гардуулах.	Дүүргийн төсөв 55.0	Шагнуулсан иргэдийн тоогоор	93	100	<p>Дүүргийн Засаг даргын шагналаар 2022 оны байдлаар нийт 443 хүнийг шагнаж урамшуулсан. Үүнд:</p> <p>-Дүүргийн Засаг даргын “Хүндэт тэмдэг”-ээр 220,</p> <p>-Дүүргийн Засаг даргын “Хөдөлмөрийн алдар медаль”-аар 223 ажилтан, албан хаагч, иргэдийг шагнаж урамшууллаа.</p>	100
4.1.10		-	Өргөдөл гомдол	13 хоног	10 хоног	Иргэдээс нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороод, Засаг	90

	Иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх, зөрчлийн тоон үзүүлэлтийг бууруулах.		шийдвэрлэлтийн хугацаа		даргын дэргэдэх хэлтэс, албадад 2022 онд нийт 4007 өргөдөл, гомдол ирснээс 94.0 хувь буюу 3776 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 1 хувь буюу 45 өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 4 хувь буюу 186 өргөдөл, гомдол одоогоор судлагдаж байна. Дүүргийн хэмжээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад нийт 1542 буюу 38.4 хувь зөрчил бүртгэгдсэн бөгөөд тус зөрчлийг агуулгаар нь авч үзвэл: Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг өдөрт нь багтаан хүлээн аваагүй- 60.18 хувь буюу 928, явцын тэмдэглэл хөтлөөгүй-26.65 хувь буюу 411, өдөрт нь багтаан шилжүүлээгүй-11.23 хувь буюу 173, буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй-1.75 хувь буюу 27, холбогдох файл хавсаргаагүй 0.19 хувь буюу 3 зөрчил тус тус бүртгэгдсэн байна. 2021 оны мөн үед өргөдөл гомдлын зөрчил нийт 224 буюу <b>28.35%</b> -ийг эзэлж байсан бол 2022 онд 549 буюу <b>28.17%</b> -ийг эзэлж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 7 цаг 6 минут байна.		
4.1.11	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Нэг цонхны үйлчилгээ”-гээр иргэдэд төрийн үйлчилгээ, мэдээ мэдээлэл, лавлагаа үйлчилгээг хүнд сурталгүй хүргэж ажиллах.	-	Үйлчлүүлсэн иргэдийн тоогоор	44542 иргэн	Дүүргийн Нэг цонхны үйлчилгээгээр 6 төрлийн 10 үйл ажиллагааг 20 мянган иргэнд хүрч үйлчилнэ	Дүүргийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний танхимд байрлах “Мэдээллийн самбар” буюу “Төрийн Үйлчилгээний ухаалаг дэлгэц”-ээр Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс албадын 24 төрлийн үйлчилгээний мэдээллийг хүргэж, нийт 48,156 иргэн үйлчлүүлж 48,156 асуудлыг шийдвэрлэсэн байна. -Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ая тухтай үзүүлэх зорилгоор Дүүргийн 1 давхрын “Нэг цонхны үйлчилгээ”-ний тахимын засварын ажил дуусаж үйл ажиллагааг хэвийн явуулж байна.	100

Засаг захиргааны анхан шатны нэгж хороог бэхжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

4.1.12	Нийслэлийн “Шилдэг хороо”, “Шилдэг хэсгийн ахлагчийн баг” шалгаруулах болзолт уралдаанд амжилттай зохион байгуулах.	-	74 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэгдсэн байна.	10 хэсгийн ахлагч	10 хэсгийн ахлагч	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/468 дугаар захирамжаар “Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг” шалгаруулах болзолт уралдаан 2 үе шаттайгаар зохион байгуулагдахаар зарлагдсан. Болзолт уралдааны нэг дүгээр үе шатанд Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх, Сүхбаатар, Налайх, Багануур дүүргүүдийн 33 хороодын ажлын алба, хэсгийн ахлагч нарын ажилд зөвлөн туслах, мэдээлэл солилцох чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсэг Дүүргийн Засаг даргын Тамгын газрын А/121 дүгээр тушаалаар байгуулагдаж, 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 11-ний өдрүүдэд ажиллаж, тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан. Болзолт уралдааны хоёрдугаар үе шатанд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/281 дүгээр тушаалаар дүүргийн шилдэг хороог шалгаруулах ажлын хэсэг байгуулагдаж, 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 30-ны өдрийг хүртэл Баянзүрх дүүргийн 43 хороо, 132 хэсгийн ахлагчийн үйл ажиллагаанд үнэлгээ өгсөн. Шалгарсан шилдэг хороо, хэсгийн ахлагч нарын мэдээлэл, тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан.	90
4.1.13		-	Нэгдсэн зөвлөгөөн, сургалт мөн хамрагдсан	196	196	Хороодын хэсгийн ахлагчдын нэгдсэн зөвлөгөөн тогтсон хугацаандаа зохион байгуулагдсан. Нийт 8 удаагийн сургалтад	100

	Дүүргийн 1-19 дүгээр хороодын хэсгийн ахлагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулан, мэдлэг ур чадварыг дээшлүүлж, харилцан туршлага судлуулах ажлыг зохион байгуулах.		хэсгийн ахлагчдын тоо			давтагдсан тоогоор 551 хороодын ажлын алба, хэсгийн ахлагч хамрагдсан. Үүнд: -Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн сантай хамтран зохион байгуулж буй “Харилцан суралцах арга зүйн сайн туршлага солилцох, нутагшуулах” болзолт уралдааны хүрээнд Хороодын засаг дарга, зохион байгуулагч нарыг 2 удаа хамруулсан. Болзолт уралдааны хүрээнд 37 сайн туршлагыг бүртгэн бусад хороодын сайн туршлагыг нутагшуулан хэрэгжүүлэхэд иргэдээс санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. -ЦЕГ-ын хар тамхитай тэмцэх газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай хамтран зохион байгуулсан Анзаар аяны хүрээнд 1-20,24 дүгээр хороодын Засаг дарга-21, Зохион байгуулагч -24, Нийгмийн ажилтан -19, Хэсгийн ахлагч -186, Нийтийн эргүүл-45, иргэдийн төлөөлөл 60 хамруулсан.	
Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангаж, цахим засаглалыг хөгжүүлнэ.							
4.1.14	Дүүргээс хэрэгжүүлж буй арга хэмжээ, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны явцыг дүүргийн албан ёсны сайт <a href="http://www.chingeltei.gov.mn/">www.chingeltei.gov.mn/</a> , цахим хуудас /Chingeltei district/-нд цаг тухай бүр байршуулах.	-	Байршуулсан мэдээ, мэдээллийн тоогоор	508	500	Тайланд хугацаанд нийт 27 хурлын бэлтгэл ажлыг хангаж, Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээлэл, өдөр тутмын мэдээ зөвлөмжийг Чингэлтэй дүүрэг / Chingeltei District фэйсбүүк пэйж хуудас, “дүүргийн онцгой комисс”-ын пэйж, Chingeltei.gov.mn вэб сайтад үнэн бодит мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажиллаж байна. “Чингэлтэй дүүрэг, Chingeltei District фэйсбүүк, пэйж цахим хуудсан дахь мэдээллийг тухай бүр шинэчлэн 1144 удаагийн цагаан мэдээ оруулснаас 1.184.773 хандалт авсан байна. Үүнээс: ХМОНХТ– 895 мэдээг бэлтгэж, нийслэлийн	100

						мэдээ 175 хуваалцаж, бусад 49 мэдээ иргэдэд хүрчээ. Нийт мэдээлэлд 4847 эерэг сэтгэгдэл, 27 сөрөг сэтгэгдэл, 36814 удаа таалагдаж, мэдээг 15469 хуваалцсан байна.	
4.1.15	Дүүргийн 30 жилийн ойн арга хэмжээ хэвлэл мэдээллийн ажлыг зохион байгуулж гэрэл зураг, дүрс бичлэг болон хувь хүний видео нэвтрүүлэг, шторк бэлтгэн ажиллах.	-	Дүрс бичлэг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.	-	100% хүрч ажилласан байна	2022 оны хагас жилийн тайланд хугацаанд Дүүргийн 30 жилийн ойн хүрээнд “Ахмадаа дээдэлье”, төрийн албан хаагчдад зориулсан Хүндэтгэлийн тоглолтын бүтэн дүрс бичлэгийг авч архивлаж ажиллав. Мөн Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх өдөрлөгийн бичлэг, Нийслэлийн Засаг даргын А/388 дугаар захирамжийн дагуу зөвшөөрөлгүй барьсан авто машины гараашнуудыг буулгах ажлын явцыг нисдэг дромээр авч архивлан баримтжуулан ажиллаж байна. Түүнчлэн 2022 оны 03-р сарын 19-ны амралтын өдөр “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-ний ажлыг 1-19 дүгээр хороодын зургийг авч мэдээ бэлтгэн оруулж ажилласан. Дүүргээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зураг авалт, видео дүрс бичлэгийг хийж 13 видео шторк пэйжид оруулж, 2 видео дүрсийг баримтжуулж ажиллалаа. Нийт 15 үйл ажиллагааны зураг авалт хийсэн байна.	100
“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд							
4.1.16	Дүүргийн төр, захиргааны байгууллагад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Улиралд 1 удаа ХШҮ хийнэ.	-	Хуулийн хугацаанд ХШҮ хийж, хэрэгжилтийг хангасан байна.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад ирсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-	10 0

						<p>ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Хяналт шинжилгээний үр дүнг үндэслэн зөвлөмж дүгнэлт боловсруулж, хэлтэс, албадад хүргүүлэн ажиллалаа. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-с 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 4007 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 3776, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 45, шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа 186 өргөдөл хүсэлт судлагдаж байна. Дүүргийн хэмжээнд нийт 1542 өргөдөл, гомдлын зөрчил бүртгэгдсэн байна.</p>	
4.1.17	<p>Дүүргийн төр, захиргааны байгууллагад ирсэн албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.</p>	-	<p>Улиралд 1 удаа ХШҮ хийнэ.</p>	-	<p>Хуулийн хугацаанд ХШҮ хийж, хэрэгжилт ийг хангасан байна.</p>	<p>Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар ирсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Харьяа Нийт 104 байгууллагад Edoc.ulaanbaatar.mn нэгдсэн системээр нийт 42368 албан бичиг ирснээс Хариутай-3991, Хариугүй-38377, үүнээс хугацаандаа шийдвэрлэсэн-40740, хугацаа хоцроож шийдвэрлэсэн 600, судлагдаж байгаа-1023, зөрчил тооцогдсон-362, хугацаа сунгуулсан-55 албан бичиг,</p>	100

						шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7.09 хоног байна.	
Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллана.							
4.1.18	Төрийн албан хаагчдыг авлигад автахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр “Авлигын эсрэг хамтдаа” сургалт үйл ажиллагааг зохион байгуулах.	-	Сургалтын тоогоор	1	2	“Эс ай Си Эй” ХХК-ийн сургалтын байгууллагаас зохион байгуулсан Төрийн албаны шударга байдлын үнэлгээ”-ний судалгаанд нийт 160 Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, тухайн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд, хамтран ажиллагч олон улсын болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг хамруулсан.  Дүүргийн Засаг даргын дэргэдэх алба, хэлтэс, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга, хороодын Засаг дарга, зохион байгуулагч нийт 196 албан хаагчийг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамруулж, мэдээлэл олгосон. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг “Авлигын эсрэг хамтдаа” сургалтад 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон 24 хороодын албан хаагчдыг хамруулж ажилласан.	100
<b>4.2 ГАДААД ХАРИЛЦАА</b>							
Дэлхийн улс орнуудын Нийслэл, дүүрэг болон хотуудтай хамтын ажиллагаа тогтоох, аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулан ажиллана.							
4.2.1	Дүүрэгтэй хамтын ажиллагаа бүхий гадаадын улс, хот, дүүрэг, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинээр хамтын ажиллагаа тогтоох.	-	хамтын ажиллагаа тогтоосон улс, хот, дүүрэг, олон улсын байгууллагын тоо	Олон Улсын 3-н байгууллагат ай хамтран	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, шинээр хамтын	Орбис Олон улсын байгууллага болон Эрүүл хотуудыг чадавхжуулах төвтэй хамтран “Чихрийн шижин болон чихрийн шижингийн шалтгаант ретинопатийн тусламж үйлчилгээний загвар бий болгох” төслийн хүрээнд “Харилцаа холбооны төлөвлөгөө боловсруулах нь” сэдэвт семинарыг 2022 оны 01 дүгээр 25-ны өдөр	100

				ажилла ж эхэлсэ н	ажиллага а тогтоосон байна	цахим хэлбэрээр зохион байгуулж, Чингэлтэй дүүрэг, Дархан-Уул, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төвийн мэргэжилтэн, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 3 албан хаагчийг хамрагдсан. Тус дүүргийн Ерөнхий боловсролын 17, 72 дугаар сургуулиудад Оросын шинжлэх ухаан, соёлын төв /РЦНК/-тэй хамтран 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр орос хэлний төвийг байгуулж, дүүргийн Боловсролын хэлтэс дарга Ш.Оюунсүрэн тус байгууллагатай Хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан. Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх зорилгоор 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдөр тус дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл, Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичи нар цаашид илүү олон салбарт хамтран ажиллахаар Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.	
<b>4.3 ТӨРИЙН БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ</b>							
4.3.1	Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жил, дүүргийн 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	Орон нутгийн төсөв 35.100.0	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтээр	6 арга хэмжээ	Төлөвлөгөөт 7 арга хэмжээ	Батлан хамгаалахын сайдын Нийслэлийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний дагуу Батлан хамгаалах хууль, тогтоомжийг сурталчлах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч хүмүүжил төлөвшүүлэхэд цэргийн штаб үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу	100



					<p>нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран зохион байгуулсан. Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 015 дугаар ангитай хамтран дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын дунд “Скат” буудлагын тэмцээнийг 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж явууллаа. Тус тэмцээнд 56 ажилтан албан хаагчид цэц мэргэнээ сорин өрсөлдөж тэргүүн байрт Тохижилт үйлчилгээний хэлтсийн дарга Б.Саруул-Од ахлагчтай баг дэд байрт Санхүү төрийн сангийн дарга Б.Нацагдорж ахлагчтай баг, гутгаар байрт Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Хангай ахлагчтай баг тус тус шалгарч тэргүүн байрт шалгарсан баг хамт олонд Цом, өргөмжлөл алтан медаль, дэд байр өргөмжлөл, мөнгөн медаль, гутгаар байрт өргөмжлөл, хүрэл медаль мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Мөн тус тэмцээнд хувийн амжилтаар хамгийн өндөр оноо авсан 2 алба хаагчийг шалгаруулж Онц буудагч тэмдэг олгосон. Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 101, Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг угтаж дүүргээс хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 014, 032 дугаар ангид алба хааж байгаа цэрэг, дайчдаа ойн баярын мэндийг хүргэж дүүргийн Засаг даргын Мэндчилгээ, Талархал, гарын бэлгийг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга дэд хурандаа О.Мөнхжаргал, тоо бүртгэлийн офицер Б.Цэдэн нар</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>гардууллаа. Тус арга хэмжээний үеэр алба хааж байгаа дайчдынхаа ар гэр, анги байгууллагын харилцан ажиллагааг хангаж, эцэг эхтэй нь уулзуулах ажлыг зохион байгууллаа. Мөн хугацаат цэргийн алба хаагчдад зориулж амны хаалт 1500 ш гар ариутгагч 20л-ийг тус бүр ангийн удирдлагуудад гардуулан хүлээлгэн өглөө. 1945 оны чөлөөлөх дайнд оролцсон дүүргийн 8 дугаар хороонд оршин суудаг ахмад дайчин С.Ванчигдоо, Баруун хилийн тулгаралтад тулалдаж явсан 6 дугаар хороонд оршин суудаг ахмад дайчин Б.Логи нарт Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101, Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэндийг хүргэж, 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль, Батлан хамгаалах яамны гарын бэлгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Баянбаатар, цэргийн штабын төлөвлөлт сургалтын офицер ахмад Н.Лхамжав нар гардуулан өглөө.</p>		
4.3.2	<p>Дайчилгааны бэлэн байдлыг хангах болон орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүн, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах.</p>	<p>Орон нутгийн төсөв 24.0</p>	<p>Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөн ий дагуу</p>	<p>Сургалт-тууд төлөвлөгдсөн.</p>	<p>Томилгоот бүрэлдэхүүний дайчилгаана удирдах болон гүйцэтгэх үүргийн дадлага, чадвар дээшилнэ.</p>	<p>Цэргийн штабыг бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудыг бие бүрэлдэхүүн, техникийг нөхөн хангах төлөвлөгөө орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөөг тус тус тодотгосон. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020, 2021 оны удирдамж, дүүргийн Засаг даргын 2022 оны Н/02 дугаар захирамжаар Зэвсэгт хүчний Жанжин штаб, нэгтгэл, анги салбарт, оногдуулан бүртгэсэн хүн, техникт тодотголыг 05, 11 дүгээр саруудад хийж Цэргийн штабын бэлэн байдал дээшилсэн.</p>	90

4.3.3	2022 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 90.0	Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд	Жил бүр хийгддэг.	Хуулийн хэрэгжилт хангагдана.	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/512, дүүргийн Засаг даргын А/143 дугаар захирамжуудыг үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 06, 07, 08-ны өдрүүдэд зохион байгуулж явууллаа. Цэрэг татлагын бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө гаргаж, цэрэг татлагын товчооны даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд нийт 32 ажил төлөвлөснөөс гүйцэтгэл 100% биелсэн. Энэ жилийн цэрэг татлагын онцлог нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг оношилгоонд цэргийн жинхэнэ албанд татах зарлан дуудах мэдэгдэл авсан цэргийн насны иргэдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулахад эрүүл мэндийн даатгал тогтмол төлсөн 718 иргэн биохими, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлэг зэрэг шинжилгээнүүдэд хамрагдсан.	90
4.3.4	Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэд, байгууллага аж ахуй нэгжид сурталчилж, төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүргэх	1.200.0	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана	6 байгууллага аж ахуй нэгж хамрагдсан	6 байгууллага аж ахуй нэгжийг бүрэн хамруулах	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамж, удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, дүүргийн Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын 24 дүгээр сургууль, Олонлог эгзэ сургууль, Соёмбо принтинг ХХК гэсэн нийт 6 байгууллага, аж ахуйн нэгжийн 170 ажилтан албан хаагчдад Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд шалган туслах ажлыг зохион байгуулахаас 147 цэргийн үүрэгтнийг тус шалгалтад хамруулж, цэргийн дүйцүүлэх албаны	100

						<p>мөнгөн төлбөрөөр орлуулан хаах болзол шаардлага хангасан 18 иргэнд хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосноос 6 иргэн 4.014.619 төгрөгийн мөнгөн төлбөрийг Нийслэлийн төрийн санд төвлөрүүлж ажилласан Цэрэг татлага, тоо бүртгэлээс завсардсан иргэдэд хуулиа биелүүлж, үүргээ ухамсарлах, Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах талаар яриа, таниулга хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтад хамрагдаагүй, болон цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоолгосон иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавьж байгууллагын удирдлагатай харилцан ажиллагааг ханган ажиллаж байна.</p>	
4.3.5	<p>Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулж явуулах</p>	18.000.0	<p>Ахлах ангийн сургуулиудын сурагчдыг бүрэн хамруулах</p>	<p>Ковид цар тахлын улмаас зохион байгуулагдаагүй</p>	<p>Дүүргийн ерөнхий боловсролын ахлах 13 сургуулийг бүрэн хамруулах</p>	<p>Цэрэг-спортын “Дөл” тэмцээний 2 дугаар шатны шалгаруулалтад оролцох ерөнхий боловсролын 13 ахлах сургуулийн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан, эмч нар, дүүргийн ЭМТ-ийн өсвөр үе хариуцсан эмч нарын бүрэлдэхүүнтэй техникийн зөвлөгөөнийг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж тэмцээнд оролцох сурагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах, хуваарь, тэмцээнд оролцуулахад эцэг эхийн зөвшөөрлийн бичиг зэрэг бусад шаардлагатай зүйлсийн талаар мэдээлэл хийж, сургуулийн баг тамирчдын бэлтгэл ажлыг хангуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг батлагдсан удирдамж, зааврын дагуу 14 төрлийн тэмцээнийг бага онооны системээр дүгнэж амжилттай зохион байгуулсан. Цэрэг-спортын “Дөл-2022” тэмцээнд тэргүүн байрт шалгарсан Т.Нарантуяа захиралтай</p>	100

						24 дүгээр сургуулийн Хар сүлд тасагт Аваргын цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, дэд байрт шалгарсан Ц.Цолмонбаатар захиралтай 23 дугаар сургуулийн Элит-23 тасагт мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, гутгаар байрт шалгарсан О.Бөхчулуун захиралтай 39 дүгээр сургуулийн Шонхор тасагт хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж, шагналыг дүүргийн удирдлагууд гардуулан өгсөн.	
--	--	--	--	--	--	--	--

**ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**5.1 НОГООН ХӨГЖИЛ**

Агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилго бүхий “Ногоон дүүрэг-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.1.1	Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд 7-19 дүгээр хороодын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, борлуулалтын үйл ажиллагааг жигдрүүлэх.	-	Нэмэгдсэн цэгийн тоо	86	98	2022-2023 оны галлагааны улиралд сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын нийт 92 цэг ажиллаж байна. Чингэлтэй дүүрэг нь 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 8 агуулах, 4 саравчинд <b>13062,5</b> тонн сайжруулсан шахмал түлшний нөөцтэй байна.	100
5.1.2	“Гэр хорооллын ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн лаг хаягдлыг байгальд халгүй аргаар шатааж устгах төсөл /Лагийн үйлдвэр/ хэрэгжүүлнэ	Улсын төсөв 1,100.0	Хэрэгжилтийн хувь	50 хувь	100 хувь	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт Улсын төсвийн хөрөнгөөр Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас хэрэгжиж байгаа түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Гэр хорооллын ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн лаг хаягдлыг байгальд халгүй аргаар шатааж устгах туршилтын төсөл”-ийн гүйцэтгэгчээр “Мөнгөн болдог” ХХК шалгаран зураг төслийн дагуу хийж гүйцэтгэж байгаа бөгөөд захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төвөөр хянуулан ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар ажлын явц 70 хувьтай хэрэгжиж байгаа ба суурь бетон цутгалтын	70

						ажил бүрэн хийгдэж, лаг хаягдлын бассейны нүхийг ухаж дуусган сэндвичийн барилгыг босгохоор ажиллаж байна.	
Дүүргийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, цэцэрлэгт хүрээлэн, ойжуулалт, ногоон байгууламжийг бүтээн байгуулна.							
5.1.3	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.	Улс, нийслэл, Дүүргийн төсөв 700.0	Нэмэгдүүлсэн хувь	126666 ширхэг мод, бут, сөөг	10-с доошгүй хувьд нэмэгдүүлнэ.	Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, талбайд “Тохижилт үйлчилгээ” ХХК нийт 15000 мод, бут сөөг шинээр тариад байна. Үүнд: 1. Ж.Самбуугийн гудамжинд 12500 ширхэг хайлаас 2. Жуулчны гудамжинд 2500 ширхэг хайлаас тарьж ургуулсан.  Намрын мод тарих аяны хүрээнд Сууц өмчлөгчдийн холбоод өөрсдийн эзэмшлийн талбайд нийт <b>410</b> модыг тарьсан.	90
5.1.4	Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх.	Улс, Нийслэл, Дүүргийн төсөв 60.0	Нэмэгдүүлсэн хувь	Нөхөн сэргээлт ойжуулалтаар 119514 ширхэг мод, бут, сөөг, Бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнд 51324 ширхэг	10-с доошгүй хувьд нэмэгдүүлнэ.	Хаврын мод тарих аяны хүрээнд дүүргийн хэмжээнд нийт 14 төрлийн (хайлаас, бургас, нарс, гацуур, улиас, агч, шар хуайс, монос, голт бор, балгана, гүйлс, буйлс, шинэс, чацаргана) буюу нийт <b>25469</b> модыг 4,000 гаруй албан хаагч, ажилчид 4 байршилд тарьсан. 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хаврын тарьсан модны ургалтын явцад хяналт тавихад 80 хувийн ургалттай байна. Намрын мод тарих аяныг 2022 оны 10 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран дүүргийн 19 дүгээр хорооны Дээд салхитын аманд байрлах “Хайрхан хөгжлийн төв” ОНӨУТҮГ-т зохион байгуулан ажиллалаа. Уг арга хэмжээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар, Хороод, Засаг даргын дэргэдэх газар, хэлтсийн 500 орчим албан хаагч нар,	90

				мод, бут, сөөг		<p>“Эрдэнэс таван толгой” ХХК, СӨХ-д оролцож нийт <b>7481</b> модыг тарьсан. Нийт 14 төрлийн (хайлаас, бургас, нарс, гацуур, улиас, агч, шар хуайс, монос, голт бор, балгана, гүйлс, буйлс, шинэс, чацаргана) буюу нийт <b>32950</b> модыг <b>4500</b> гаруй албан хаагч, ажилчид тарьсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ “Хоймор хайрхан амралт” ОНӨТҮГ-10106 мод</li> <li>➢ “Хайрхан хөгжлийн төв” УТҮГ- 20744 мод</li> <li>➢ 293 дугаар цэцэрлэгийн хашаа- 100 мод</li> <li>➢ “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” УТҮГ- 2000 мод</li> </ul>	
--	--	--	--	----------------------	--	---	--

Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлж, өндөр хөгжилтэй орнуудын хогны менежментээс туршлага судлан хэрэгжүүлнэ.

5.1.5	Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллах.	Дүүргийн төсөв 11,000.0	Тээвэрлэсэн хог хаягдлын тоо, хэмжээ /өссөн дүнгээр/	29,000 рейс 170,00 0 тонн хог хаягдал	31,000 рейс 185,000 тонн хог хаягдал	Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, Найши трейд ХХК-д дүүргийн 1-20 дугаар хороодын айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудын хог хаягдлыг тээвэрлэн ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, Найши трейд ХХК-д жилийн эцсийн байдлаар нийт 46,667 рейсээр 189,000 тонн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэн ажиллаж байна.	90
-------	---	-------------------------	--	--	--	---	----

**ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Дүүргийн хэмжээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх, улс, нийслэл, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн санд тусгах батлуулах**

6.1.1	Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг дүүргийн Засаг даргын Тамгын	-	Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө	Монгол Улсын 2022 оны	Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө	Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн хуулийн хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажилласан.	100
-------	--	---	--------------------------------	-----------------------	--------------------------------	--	-----

	газрын болон дэргэдэх хэлтэс, албад, хороодоос авч нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ.		оруулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн хуулийн хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх.	төсвийн төсөлд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 75 төсөл, арга хэмжээн, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 55 төсөл арга хэмжээн	оруулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн хуулийн хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.		
6.1.2	Дүүрэгт улс, нийслэл, дүүргийн төсвийн болон нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлийг хянах.	-	Төсөл, арга хэмжээ бүрд хяналт тавьж, хэрэгжилтийг тооцох	162 төсөл, арга хэмжээ	Дүүрэгт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдэд тухай бүрд хяналт	Дүүрэгт хэрэгжиж буй хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээнүүдэд тухай бүрд хяналт тавьж ажилласан байна.	90



					тавьж ажилласа н байна.		
Дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн биелэлтийг гаргах							
6.1.3	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн боловсруулна.	-	Жилд 4 удаа биелэлт авах	82.09%	85%	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам авч дүүргийн ИТХ-д танилцуулан ажиллаж байна. Жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн ИТХ-д танилцуулахаар ажиллаж байна.	90

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР